

**ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРИЙН ЗАРИМ ЧИГ
ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

АГУУЛГА	Хуудас
1. Оршил	3
2. Гэрээний үүргийн хэрэгжилт	4
2.1. Гэрээний тусгай нөхцөлийн хэрэгжилт	4
3. Гэрээний хавсралтын хэрэгжилт	
Хавсралт А: Үйлчилгээний тодорхойлолт ба хуваарь	8
3.1. А-1: Үйлчилгээний үр дүнгийн тодорхойлолтын хэрэгжилт	8
3.2. А-2: Үйл ажиллагааны хуваарийн хэрэгжилт /2018/	9
4. Хавсралт Б-Тайлагнах үүрэг хариуцлага	12
5. Хавсралт В-Үйлчилгээ үзүүлэгчийн голлох боловсон хүчин	12
5.1. В-1: Үндсэн орон тооны ажилтан	12
5.2. В-2 Орон тооны бус бүрэлдэхүүн	13
6. Хавсралт Г-Үйлчилгээ үзүүлэгчийн үзүүлэх үйлчилгээ болон техник хэрэгсэл	13
7. Хэрэгжилтийн тайлангийн хавсралтууд	15
7.1. Хавсралт 1. ТМЗ-д эрх олгох шалгалтад бэлтгэх сургалтын мэдээ	15
7.2. Хавсралт 2. ТМЗ-д эрх сунгах сургалтын мэдээ	15
7.3. Хавсралт 3. ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалтын мэдээ	16
7.4. Хавсралт 4. ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдүүдийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын ажлын нэгдсэн тайлан	17
7.5. Хавсралт 5. ТМЗ-ийн эрх, ТМЗҮ эрхэлж буй хуулийн этгээдүүдийн тусгай зөвшөөрлийг хүчингүйд тооцсон мэдээлэл	19
7.6. Хавсралт 6. Шалгалтын төстийн сан бүрдүүлэх, татварын чиглэлийн олон улсын бичиг баримт орчуулах, тайлбарлах, зөвлөмж боловсруулах, судалгааны ажил хэрэгжүүлэх	22
7.7. Хавсралт 7. ТМЗ-ийн эрхийг сунгах тасралтгүй боловсролын сургалт	24
7.8. Хавсралт 8. ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдүүдийн удирдах ажилтны зөвлөгөөн	25
7.9. Хавсралт 8А. Төр мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдүүдийн хамтарсан ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ-2018	26
7.10. Хавсралт 9. АОТСА-2018 Mongolia Олон улсын татварын чуулганы талаархи хураангуй тайлан мэдээ	28
7.11. Хавсралт 10. Улсын бүртгэлийн газраас ТМЗҮ үзүүлж буй ААНБ-дын нэрсийг авч, судалгаа, дүгнэлт хийсэн мэдээлэл	32
7.12. Хавсралт 11. “Татварын хуулийг хэн сайн мэдэх вэ” оюутны 12 дахь удаагийн тэмцээн	33
7.13. Хавсралт 12. Татварын бүртгэл -2018 улсын V олимпиад	36
7.14. Хавсралт 13. ТМЗ-ийн тангараг өргөх ёслол	39
7.15. Хавсралт 14. ТМЗН-ийн Ёс зүй, Хяналтын Менежментийн Хорооны ажиллах журам	40

7.16. <i>Хавсралт 15.ТМЗН-ийн гишүүд,ТМЗҮ эрхэлж буй хуулийн этгээдийн ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам</i>	45
8. Хэрэгжилтийн тайлангийн баталгаажуулалт	48

1. ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРИЙН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэх СЯ-1605 тоот гэрээг Захиалагч Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар, Гүйцэтгэгч байгууллагаар Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг оролцож, 2016 оны 7 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан болно. Гэрээний хугацаа 2017 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар болж, 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн гэрээ дүгнэсэн актыг үндэслэн гэрээний хүчин төгөлдөр хугацааг 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хүртэл гурван жилийн хугацаатайгаар сунгасан болно.

Тус гэрээний 2018 оны гүйцэтгэлийн тайланг:

- ✓ Гэрээний тусгай нөхцөлийн
- ✓ Үйлчилгээний үр дүнгийн тодорхойлолтын
- ✓ Үйл ажиллагааны хуваарийн
- ✓ Үндсэн орон тооны боловсон хүчний
- ✓ Орон тооны бус бүрэлдэхүүний, үйлчилгээ үзүүлэгчийн үзүүлэх үйлчилгээ болон техник хэрэгсэлийн гүйцэтгэл
- ✓ Хавсралтууд гэсэн ангилал тус бүрээр тайлагнав.

Товчилсон нэр томъёо:

ТМЗҮТХ - Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хууль

ТМЗН - Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг

ТМЗҮ - Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ

ТМЗ - Татварын мэргэшсэн зөвлөх

ГЕН - Гэрээний ерөнхий нөхцөл

ГТН - Гэрээний тусгай нөхцөл

2. ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

ТМЗН нь ТМЗҮТХ, Засгийн газрын 2016 оны 165 дугаар тогтоол, ТМЗН-ийн дүрмийн дагуу үйл ажиллагааны ил тод байдлыг ханган гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийн хүрээнд үйл ажиллагаагаа гүйцэтгэсэн болно.

2.1 Гэрээний тусгай нөхцөлийн хэрэгжилт

ГТН-3.1.1. ТМЗ-д эрх олгох, сунгах сургалтын хөтөлбөр, шалгалт авах журмыг тус тус батлуулан мөрдүүлж, шалгалтыг зохион байгуулах:

ТМЗ-д эрх олгох, эрхийг сунгах сургалтын хөтөлбөрийг 2017 оны 5 дугаар сарын 4-ний өдөр Сангийн яамны НБББГ-т хүргүүлж батлуулсан бөгөөд энэхүү батлагдсан хөтөлбөрийн дагуу 2018 оны сургалтыг зохион байгуулж байна. Үүнд:

Татварын мэргэшсэн зөвлөхөд эрх олгох сургалт

- Улаанбаатар хотод 9 удаа зохион байгуулж, 257 нягтлан бодогч хамрагдаж, сургалтын журмын 3-р зүйлийн 3.6.1-д заасан шаардлагыг хангасан 223 суралцагч батламж авсан.
- Орон нутагт Баянхонгор аймагт-14 нягтлан бодогч, Хөвсгөл аймагт-15, Ховд аймагт-15, Өвөрхангай аймагт-8, Говь-Алтайаймагт-14 нягтлан бодогчид, Улаанбаатар хотын алслагдсан дүүрэг Багануурт-15 нягтлан бодогчид тус тус хамрагдаж, сургалтад хамрагдсан батламж авсан. /Хавсралт-1/

Татварын мэргэшсэн зөвлөхийн эрх сунгах сургалтыг:

- ТМЗ-ийн эрхийг анх удаа сунгах сургалтыг 2 удаа зохион байгуулж, 85 ТМЗ гишүүд;
- ТМЗ-ийн эрхийг дахин сунгах сургалтыг 2 удаа зохион байгуулж, 73 ТМЗ гишүүд тус тус хамрагдсан. /Хавсралт-2/

Татварын мэргэшсэн зөвлөхөд эрх олгох, сунгах шалгалт авах журам

Сангийн сайдын 2018 оны 5 дугаар сарын 4-ны өдрийн 94 тоот тушаалаар батлагдсан шалгалтын бүрэлдэхүүн нь шалгалтыг ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалт авах журмын дагуу зохион байгуулан ажиллаж байна.

ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалт зохион байгуулах.:

- 2018 оны эхний хагас жилийн байдлаар ТМЗ-д эрх олгох шалгалтад 34 нягтлан бодогч тэнцэж, Сангийн сайдын 6 дугаар сарын 25-ны өдрийн 156 тоот тушаалаар 34 татварын мэргэшсэн зөвлөхийн эрхийг 3 жилээр олгохоор шийдвэрлүүлсэн. ТМЗ-д эрх олгох 2018 оны сүүлийн хагас жилийн шалгалтыг 12-р сарын 20-22-ны өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөн шалгалтын бүртгэлийн ажлыг эхлүүлээд байна.
- 2018 оны эхний хагас жилийн байдлаар ТМЗ-ийн эрх сунгах шалгалтад нийт 89 ТМЗ-үүд хамрагдаж, Сангийн сайдын 6 дугаар сарын 25-ны өдрийн 156 тоот тушаалаар 89 татварын мэргэшсэн зөвлөхийн эрхийг 3 жилээр сунгахаар шийдвэрлүүлсэн. 2018 оны сүүлийн хагас жилийн ТМЗ-ийн эрх сунгах шалгалт 12-р сарын 8;14 –ний өдрүүдэд зохион байгуулагдахаар төлөвлөн ажиллаж байна. /Хавсралт-3/

ГТН-3.1.2. ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх; татварын мэргэшсэн зөвлөхийн хуулийн этгээдийг арга зүйн удирдлага, зөвлөгөө мэдээллээр хангаж, тэдгээрийн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх:

ТМЗҮТХ батлагдснаар нийт 61 хуулийн этгээд ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан бөгөөд 2018 оны 12 дугаар сарын байдлаар 39 хуулийн этгээд үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байна.

Мэргэжлийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавих зорилгоор Сангийн сайдын 2018 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 117 тоот тушаалаар ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 24 компанийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхээс 23 компанийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж ажиллалаа.

Хяналтын шалгалтаар ТМЗҮТХ-ийн 10-р зүйлийн 10.1.2, 10.1.6-д заасан зөрчил голлон илэрсэн байна.

Хяналт шалгалтын ажлын хэсгийн нэгдсэн дүгнэлтээр ТМЗҮТХ-ийн 10-р зүйлд заасан зөрчил гаргасан 4 хуулийн этгээдийн ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлэн, хяналт шалгалтад хамрагдсан ТМЗҮ эрхэлж буй хуулийн этгээдүүдэд Үндэсний архивын газрын даргын 2007 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 59 дүгээр тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох, даалгавар өгч ажилласан байна.

Сангийн сайдын 2018 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн 171 тоот тушаалаар “Даймондтакс ТМЗ” ХХК-ийн нэр “Файнаншил про такс ТМЗ” ХХК болж өөрчлөгдөж, зохих өөрчлөлтийг улсын бүртгэлд хийлгүүлээгүй, мөн ажлын байр нүүж, үйл ажиллагаа нь жигдрээгүй зэргээс шалтгаалан хяналт шалгалтыг хойшлуулсан болно. /Хавсралт 4/

ГТН-3.1.3. Мэргэжлийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавих, татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгуулах саналыг Захиалагчид тавьж шийдвэрлүүлэх:

ТМЗН-ийн Удирдах зөвлөлийн 2017 оны 9 дүгээр сарын 27-ний өдрийн 006 тоот тогтоолоор “Ёс зүйн дүрэм”-д өөрчлөлт оруулан баталж, мөрдөж байна. Ёс зүйн хяналтын менежментийн хороо /цаашид ЁЗХМХ гэх/ нь 2018 оны 1 сард ЁЗХМХ-ны ажиллах журамд нэмэлт өөрчлөлтийг оруулан УЗ-ийн хуралдаанаар шинэчлэн батлуулж, мөрдөн ажиллаж байна. /Хавсралт 14/

Шинэчлэгдсэн журмын хүрээнд “ТМЗН-ийн гишүүд, ТМЗҮ эрхэлж буй хуулийн этгээдийн ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ыг боловсруулж, батлуулан мөрдлөг болгон ажиллаж байна. /Хавсралт 15/

Татварын мэргэисэн зөвлөхийн эрхийг түтгэлзүүлэх, хүчингүйд тооцох: /Хавсралт 5/

- 2017 оны сүүлийн хагас жилд Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 377 тоот тушаалаар ТМЗ-ийн эрхийн хугацаа нь дууссан, сунгуулах хүсэлтээ ирүүлээгүй нийт 12 гишүүдийн эрхийг,
- Сангийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 239 тоот тушаалаар ТМЗ-ийн ёс зүйн дүрмийг ноцтой зөрчсөн нь тогтоогдсон Ц.Уянгын /Н/11-0582/ ТМЗ-ийн эрхийг,
- Сангийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 248 тоот тушаалаар “Интоор финанс ТМЗ” ХХК, “Калкүлюс ТМЗ” ХХК-иудын ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүйд тооцуулж шийдвэрлүүлсэн байна.

ГТН-3.1.4. Гишүүдийн татварын хэмжээ, сургалт, шалгалтын болон бусад нэмэгдэл үйлчилгээний төлбөр хураамжийн хэмжээг Захиалагчтай тохиролцон тогтоож мөрдүүлэх

Гишүүдийн татварын хэмжээ, сургалт, шалгалтын болон бусад нэмэгдэл үйлчилгээний төлбөр хураамжийн хэмжээг Захиалагчтай тохиролцон тогтоосон хэмжээнд даган мөрдүүлсэн.

ГТН-3.1.5. Шалгалтын тестийн сан бүрдүүлэх, татварын чиглэлийн олон улсын бичиг баримт орчуулах, тайлбарлах, зөвлөмж боловсруулах, судалгааны ажил хэрэгжүүлэх

Шалгалтын тестийн сан бүрдүүлэх:

- Шалгалтын тестийн санг баяжуулах зорилгоор сургалт судалгааны менежментийн хорооноос хичээл тогтмол заадаг багш нараас хөтөлбөрийн агуулгад нийцсэн тестүүдийг авч, давхардлыг арилган 2018 оныг дуустал бүх тестийг нэгтгэж “Тестийн эмхтгэл-VI”-номыг хэвлүүлэн суралцагчдын хүртээл болгосон. /Хавсралт-6/

Татварын чиглэлийн олон улсын бичиг баримт орчуулах, тайлбарлах:

- Татварын нэр томъёоны тайлбар толь бичгийг хэвлүүлэн нийтийн хүртээл болгох зорилгоор толь бичиг эмхтгэх ажлыг эхлүүлээд байна.
- “AOTCA 2018 MONGOLIA” ОУ-ын татварын чуулганыг зохион байгуулсантай холбогдуулан “ОУ-ын хурлын илтгэлүүдийн эмхтгэл” номыг англи, монгол хэл дээр, “Олон улсын татвар, татварын бодлого 21 зуунд” сургалтын гарын авлагыг англи, монгол хэл дээр, “Монгол Улсын татварын тогтолцоо” номыг монгол, англи, япон хэл дээр хэвлүүлэн нийтийн хүртээл болголоо. /Хавсралт-6/

Судалгааны ажил хэрэгжүүлэх:

- Санхүү, татвар, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр хийх судалгааг дэмжиж, хөгжүүлэхийн зэрэгцээ эдгээр салбарт тулгамдаж буй асуудлыг судалж илрүүлэн, түүнээс гарах арга зам, шийдлийг шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаанд тулгуурлан боловсруулан олон нийт, холбогдох эрх бүхий байгууллагуудад санал, зөвлөмж хүргүүлэх ТМЗ-ийн эрхээ сунгуулах гишүүдээр бие даалт болон судалгааны ажил хийлгүүлж байна. Шаардлагад нийцсэн судалгааны ажлуудаас сонгон англи хэл дээр хөрвүүлэн олон улсын “Татвар ба Бизнес” сэтгүүлд хэвлүүлэн нийтийн хүртээл болгон ажиллаж байна. /Хавсралт 6/

ГТН-3.1.6. Тус гэрээнд заасан төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэхдээ татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн эрх олгох. Сунгах сургалт, шалгалтыг төлбөртэй зохион байгуулж болох бөгөөд 1 цагийн сургалтын төлбөрийн дээд хязгаарыг 3500 /гурван мянга таван зуун/ төгрөг; 1 цагийн шалгалтын төлбөрийн дээд хязгаарыг 8000 /найман мянга/ төгрөг байхаар тооцох

ТМЗ-д эрх олгох, сунгах сургалтын 1цагийн сургалтын төлбөрийн дээд хязгаарыг 3500 /гурван мянга таван зуун/ төгрөг, 1 цагийн шалгалтын төлбөрийн дээд хязгаарыг 8000 /найман мянга/ төгрөг байхаар тогтоож дагаж мөрдөж ажилласан.

ГТН-3.1.7. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн “Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох тухай” 199 дүгээр тогтоолын дагуу Монгол Улсын татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн эрх олгох, сунгах шалгалтад тэнцсэн иргэн, тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтын хуулбар хувь, төлсөн татварын хэмжээг нэгтгэсэн жагсаалтыг Захиалагч болон холбогдох байгууллагад нь ирүүлж байх

МУ-ын татварын мэргэшсэн зөвлөхийн эрх олгох, сунгах шалгалтад тэнцсэн иргэд, тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтын хуулбар хувь, төлсөн татварын хэмжээг нэгтгэсэн жагсаалтыг Захиалагчид хүргүүлж ажилласан.

ГТН-3.1.8. Нийгэмлэг өөрийгөө санхүүжүүлэх зарчмын дагуу үйл ажиллагаа явуулах бөгөөд иргэний хувьд толөх татварын дээд хэмжээ 120000 /нэг зуун хорин мянга/ төгрөгөөс; Татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээдийн элсэлтийн хураамж нь 2000000 /хоёр сая/

төгрөгөөс; Татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээдийн төлөх татварын дээд хэмжээ нь татварын итгэмжлэгдсэн үйлчилгээний орлогын 0,5 хувиас тус тус хэтрэхгүй байх

Бүх гишүүдийн хурал болон удирдах зөвлөлийн хуралдаанаар Татварын мэргэшсэн зөвлөхийн гишүүний татварын дээд хэмжээ 120000 /нэг зуун хорин мянга/ төгрөг, Татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээдийн элсэлтийн хураамж нь 2000000 /хоёр сая/ төгрөг, Татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээдийн төлөх татварын дээд хэмжээ нь татварын итгэмжлэгдсэн үйлчилгээний орлогын 0,5 хувиас тус тус хэтрэхгүй байхаар тогтоож, мөрдөж ажилласан.

ГТН-3.1.9. Гэрээ гүйцэтгэгч нь гэрээний 3.1.6, 3.1.8-д зааснаас бусад аливаа төлбөр хураамж татвар зэргийг гишүүд болон хуулийн этгээдээс авахгүй байх

ТМЗН нь гэрээнд зааснаас бусад аливаа төлбөр, хураамж татварыг гишүүд болон хуулийн этгээдээс авахгүйгээр, хүлээсэн үүргээ биелүүлсэн болно.

3. Гэрээний хавсралтын хэрэгжилт

Хавсралт А-Үйлчилгээний тодорхойлолт ба хуваарь

ТМЗН нь ТМЗҮТХ-ийн 18 дугаар зүйлийг үндэслэн энэхүү гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийн хүрээнд дараах үйл ажиллагааг гүйцэтгэсэн болно. Үүнд:

3.1 А-1 Үйлчилгээний үр дүнгийн тодорхойлолтын хэрэгжилт

Үйлчилгээ 1- Татварын мэргэшсэн зөвлөхийн эрх олгох шалгалтад бэлтгэх сургалт

- Сургалтын 70 дээш хувьд хамрагдсан нягтлан бодогчдод батламж олгож, шалгалт өгөх эрхийг нээж өгсөн. Сургалтын ирцийг хянаснаар суралцагчдын идэвхи, чанар сайжирсан санал асуулгыг дүнгээс харагдаж байна.

Үйлчилгээ 2- Татварын мэргэшсэн зөвлөхийн эрхийг сунгах тасралтгүй боловсролын сургалт

- 2018 онд тасралтгүй боловсрол олгох сургалтыг цахим хэлбэрт шилжүүлэн 3 удаагийн цахим сургалтыг СТОУС-15, Мэргэжлийн ёс зүй, Уул уурхайн салбарын бүртгэл, ХАА-н салбарын бүртгэл зэрэг хичээлээр зохион байгуулсан нь ТМЗ гишүүдэд орон зайнаас үл хамааран сургалтад хамрагдах боломж бололцоог хангаж өгч, гишүүдийн талархлыг хүлээсэн сургалт болж чадлаа. */Хавсралт 7/*
- ТМЗ болон татвар төлөгч иргэдийн хэрэгцээ шаардлагад тулгуурласан сэдвүүдээр тасралтгүй боловсрол олгох сургалтыг зохион байгуулахын зэрэгцээ татварын хууль тогтоомжийн шинэчлэл өөрчлөлт, тулгамдаж буй асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэх, ТМЗ-ийн эрхийн хугацааг сунгуулах гишүүдээр судалгааны ажил хийлгэж, хамгаалуулах зэрэг ажлуудыг зохион байгуулж байна. Эдгээр ажлын үр дүнд татварын мэргэшсэн зөвлөхүүдийн оролцоо идэвхи сайжирч, чанар, чадвар нэмэгдэж байна. */Хавсралт 6/*
- Мөн ТМЗ-ийн эрхийн хугацааг сунгуулах гишүүдээр судалгааны ажил хийлгэж, хамгаалуулах ажлуудыг зохион байгуулж шаардлагыг бүрэн хангасан судалгааны ажлуудаас сонгон англи хэл дээр хөрвүүлэн олон улсын “Татвар ба Бизнес” сэтгүүлд хэвлүүлэн нийтийн хүртээл болгон ажиллаа. */Хавсралт 6/*
- “АОТСА 2018 MONGOLIA” ОУ-ын татварын чуулганы хүрээнд 9-р сарын 11-ний өдөр ОУ-ын татварын сургалтыг “Олон улсын татвар, татварын бодлого 21 зуунд” сэдвээр зохион байгууллаа. */Хавсралт 6/*

Үйлчилгээ 3- Татварын мэргэшсэн зөвлөхийн хуулийн этгээдийг арга зүйн удирдлага, зөвлөгөө мэдээллээр хангах

- ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдүүдийн удирдах ажилтны зөвлөгөөн */Хавсралт 8/*
- Төр мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдүүдийн хамтарсан ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ-2018 */Хавсралт 8 А/*
- “АОТСА 2018 MONGOLIA” олон улсын татварын чуулганыг зохион байгуулж ТМЗҮ эрхэлж буй хуулийн этгээдүүд болон ТМЗ гишүүдийг мэдээллээр ханган ажиллаа. */Хавсралт 9/*

Үйлчилгээ 4- Шалгалтад зориулж хичээл тус бүрээр иж бүрэн тестийн сан бүрдүүлэх:

- Татварын хууль тогтоомжийн шинэчлэлтэй холбогдуулан 2018 оныг дуустал тестүүдийг эмхтгэн гаргасан. */Хавсралт-6/*

3.2 А-2: Үйл ажиллагааны хуваарийн хэрэгжилт /2018/

ТМЗН нь энэхүү гэрээнд заасан хуваарийн дагуу үйл ажиллагаагаа гүйцэтгэсэн болно. Үүнд:

№	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хэрэгжилт
I. Үндсэн чиглэлийн хүрээнд			
1	2018 оны ажлын төлөвлөгөөг захиалагчид хүргүүлж, батлуулах	2 сарын 15	СЯ-ны НБББГ-т ТМЗН-ийн 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 02/04 албан тоотойр хүргүүлж батлуулсан болно.
2	2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг, үйл ажиллагааны тайлангийн хамт захиалагчид хүргүүлэх	2 сарын 15	СЯ-ны НБББГ-т ТМЗН-ийн 2018 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн 02/15 албан тоотойр хүргүүлсэн болно.
3	ТМЗ-д эрх олгоход бэлтгэх, эрхийг сунгах сургалтын төлөвлөгөөг хагас жилээр урьдчилан гаргаж, мэдээлэх, төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулах	2; 9-р сард	<p><u>ТМЗ-д эрх олгох шалгалтад бэлтгэх сургалтыг:</u> /Хавсралт 1/ Улаанбаатар хотод 9 удаа зохион байгуулж, 257 нягтлан бодогч хамрагдаж, сургалтын журмын 3-р зүйлийн 3.6.1-д заасан шаардлагыг хангасан 223 суралцагч батламж авсан.</p> <p>✓ Орон нутагт Баянхонгор-14 нягтлан бодогч, Хөвсгөл-15, Ховд-15, Өвөрхангай-8, Говь-Алтай-14 нягтлан бодогчид, Улаанбаатар хотын алслагдсан дүүрэг Багануурт-15 нягтлан бодогчид тус тус хамрагдаж, сургалтад хамрагдсан батламж авсан.</p> <p><u>Татварын мэргэшсэн зөвлөхийн эрх сунгах сургалтыг:</u> /Хавсралт 2/ ✓ ТМЗ-ийн эрхийг анх удаа сунгах сургалтыг 2 удаа зохион байгуулж 85 ТМЗ гишүүд; ✓ ТМЗ-ийн эрхийг дахин сунгах сургалтыг 2 удаа зохион байгуулж 73 ТМЗ гишүүд тус тус хамрагдсан.</p>
4	ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалт авах шалгалтын бүрэлдэхүүн томилох	II улиралд	Сангийн сайдын 2018 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн 94 тоот тушаалаар ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалт авах комиссын бүрэлдэхүүнийг томилон баталсан.
5	ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалт зохион байгуулах	6;12-р сард	<p><u>ТМЗ-д эрх олгох шалгалт:</u> 2018 оны эхний хагас жилийн байдлаар ТМЗ-д эрх олгох шалгалтад нийт 217 нягтлан бодогч хамрагдсанаас 34 шалгуулагч тэнцэж ТМЗ-ийн эрхийг шинээр авсан. /Хавсралт 3/ <u>Татварын мэргэшсэн зөвлөхийн эрх сунгах шалгалтыг</u> анх удаа, дахин сунгах гэсэн 2 хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд 2018 оны эхний хагас жилийн байдлаар: /Хавсралт 3/ ✓ Анх удаа сунгах шалгалтад 47 ✓ Дахин сунгах шалгалтад 42 татварын мэргэшсэн зөвлөх хамрагдсан байна.</p>
II. ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн хүрээнд			

6	СЯ, ТЕГ, ТМЗН хамтран ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүдэд хуулийн нөхцөл шаардлагыг хэрхэн ханган ажиллаж байгаа талаар хяналт шалгалт хийх, тэдгээрийн хариуцлагыг дээшлүүлэх, хууль эрх зүйн хэрэгжилтийг хангуулан ажиллах ажлыг зохион байгуулах	4;5-р сард	Сангийн сайдын 2018 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 117 тоот тушаалын дагуу Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 24 хуулийн этгээдийн үйл ажиллагаанд удирдамжийн дагуу хяналт шалгалтыг хийж, ажлын тайланг хүргүүлээд байна. /Хавсралт 4/
7	Улсын бүртгэлийн газраас татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээ үзүүлдэг ААНБ-ын жагсаалт, судалгаа гаргуулан авах	2 сард	Сангийн яамнаас 2018 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 7/760 тоот албан бичгээр ирсэн үндсэн болон туслан эрхлэх үйл ажиллагааны чиглэлд нягтлан бодох бүртгэл, санхүү, татварын зөвлөх үйлчилгээ гэсэн ангилал бүхий хуулийн этгээдүүдийн мэдээллийн дагуу тус нийгэмлэг нь санхүүгийн тайлангийн төлөвт нь судалгаа хийсэн үр дүнг 5 сарын 3-нд хүргүүлэн ажиллаа. Судалгаанд хамрагдсан 611 хуулийн этгээдээс 281 үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс тусгай зөвшөөрөлтэй 25, тусгай зөвшөөрөлгүй 256 ААН Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээг тусгай зөвшөөрөлгүйгээр хэрэгжүүлж байх магадлалтай гэж үзэж байна. /Хавсралт 10/
8	Татварын тайлан тооцооны үнэн зөв байдалд хяналт тавих механизмыг сайжруулах зорилтын хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулан гарсан санал, дүгнэлтийг төрийн байгууллагуудад хүргүүлэх	10 сард	Төр, мэргэжлийн байгууллага, ТМЗ компаниудын хамтын ажиллагаа, ТМЗҮТХ, Татварын хуулийн хэрэгжилт, ТМЗҮ-ний хөгжлийн чиг хандлага, тулгамдаж буй асуудал, ололт амжилтын талаар хэлэлцэж, дүрэм, журмын зохицуулалтыг сайжруулах тал дээр нэгдмэл ойлголтод хүрэх, үр дүн, шийдлийг тодорхойлох зорилготойгоор ЗӨВЛӨЛДӨХ-2018 уулзалтыг 11-р сарын 21-ний өдөр зохион байгуулж, гарсан шийдвэр дүгнэлтийг танилцуулан, цаашид хийх ажлаа тодорхойлоо. /Хавсралт 8/
Ш. Олон нийтийн ажлын хүрээнд			
9	“Татварын хуулийг хэн сайн мэдэх вэ” оюутны тэмцээн	4;5-р сард	12 дахь удаагаа зохион байгуулагдаж буй уг тэмцээнийг “Е-Баримтын хэрэгжилт зах, худалдааны төвүүдэд” сэдвийн хүрээнд: ✓ Тавдугаар сарын 9,10-нд Нарантуул зах дээр судалгаа, сурталчилгааны өдөрлөг, ✓ 11-нд Татварын ерөнхий газарт асуулт хариултын тэмцээн хэлбэрээр гурван өдөр зохион байгууллаа. 1-р байранд МУИС-ийн “Инфити” баг 2-р байранд МУИС-ыг “Тэмүүлэл” баг 3-р байранд МанИС-ийн “Татварын титанууд” баг шалгарсан байна.

			Тэмцээний үеэр Нарантуул зах дээрх өдөрлөгийг 2 өдөр дараалан МАСС ТВ-ээр шууд дамжуулалт хийлгүүлж, тэмцээний талаархи мэдээллийг 8 сайтаар түгээсэн. /Хавсралт 11/
10	“Татварын бүртгэл-2018” Улсын олимпиад	10;11-р сард	“Татварын бүртгэл-2018” Улсын V олимпиад 11-р сарын 21;30-ны өдрүүдэд 2 үе шаттайгаар 1-р бүлэг “Нягтлан бодогч”, 2-р бүлэг “Оюутан” гэсэн ангиллаар амжилттай зохион байгууллаа. Олимпиадад 300 гаруй хүн бүртгүүлж, 1-р шатны шалгаруулалтад 268 хүн оролцож мэдлэг оюунаа сорьсноос 2-р шатанд бүлэг тус бүрээс 20,20 оролцогч шалгарч үлдсэн. 2-р шатны шалгаруулалтанд 1-р бүлгийн 1-р байр Б.Ганбагана /МанИС-ийн багш/, 2-р байр Б.Бат-Амгалан /СЭЗИС-ийн багш/, тусгай байр Х.Амирдийбазар /ОБ пластик” ХХК-ийн нягтлан бодогч тус тус шалгарч, 2-р бүлэгт СЭЗИС-ийн оюутнууд эхний 3 байрыг эзэлсэн байна. /Хавсралт 12/
11	Татварын мэргэшсэн зөвлөхийн тангараг өргөх ёслол	6;12-р сард	Тангараг өргөх ёслолын арга хэмжээг 6 дугаар сарын 28-ны өдөр Сангийн яамны Хүндэтгэлийн танхимд зохион байгууллаа. Эхний хагас жилийн байдлаар 34 нягтлан бодогч шинээр ТМЗ эрх авч, 89 нягтлан бодогч ТМЗ-ийн эрхээ сунгуулсан байна. /Хавсралт 13/
12	"Шилдэг -2018" ТИНБ-ын баяр	12 сард	ТМЗ-ийн баяр 2017-2018 шинэ жилийн цэнгүүнийг 2017 оны 12 сарын 27-нд зохион байгуулан шилдэг ТМЗ-өөр Р.Хишигнэмэх /"Эрнст энд янг ТМЗ" ХХК/, шилдэг багшаар ХААИС-ийн багш С.Баярхүү, шилдэг ТМЗ компаниар “PWC ТМЗ” ХХК, ТМЗН-ийн шилдэг ажилтнаар Г.Хишигзул нар тус тус шалгарлаа. “Шилдэг ТИНБ-2018” ТМЗ-үүдийн баярыг 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулахаар бэлтгэл ажлаа эхлүүлээд байна.
13	“АОТСА-2018” Ази Номхон Далайн Орнуудын Татварын Мэргэшсэн Зөвлөх Нийгэмлэгүүдийн Холбооны ээлжит хурлыг Улаанбаатар хотод зохион байгуулах	9 сарын 11-15	“АОТСА 2018 MONGOLIA” Олон Улсын татварын чуулганыг 9-р сарын 11-15-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Чуулганд гадаадын – 282, дотоодын 260 төлөөлөгчид оролцсон. ОУ-ын чуулганы зохион байгуулснаар бид: ✓ Дэлхийн татварын зөвлөхүүдийг нэгтгэсэн ✓ Монгол Улсын нэр хүндийг олон улсын төвшинд өргөсөн ✓ Монгол Улсын ТМЗН-ийн чансааг таниулсан ✓ Монголын санхүү, татвар, бүртгэлийн мэргэжилтнүүдийг шинэ мэдлэг мэдээллээр цэнэглэсэн ✓ Дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн илтгэгчдийг нэг дор цуглуулж чадсан

			<ul style="list-style-type: none"> ✓ Монгол улсад тодорхой хэмжээний мөнгөн урсгалыг оруулсан / ✓ АОТСА-ын шинэ удирдлагыг сонгох түүхэн цаг үеийг гэрчилсэн ✓ Хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлсэн ✓ Монгол Японы хамтарсан сайн дурын нийгэмлэг байгуулсан ✓ Бизнес түншлэлийг өргөжүүлсэн. <p style="text-align: right;">/Хавсралт 9/</p>
--	--	--	--

4. Хавсралт Б-Тайлагнах үүрэг хариуцлага

ТМЗН-ийн 2017 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайланг, 2018 оны үйл ажиллагааны хуваарийн төслийн хамт 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдөр, 2018 оны үйл ажиллагааны хуваарийг 2018 оны 01 дүгээр сарын 10-ны 02/04 албан тоотоор, Удирдах зөвлөлөөр хэлэлцэн баталсан 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн 02/15 тоот албан тоотоор Захиалагч талд хүргүүлж ажилласан.

5. Хавсралт В-Үйлчилгээ үзүүлэгчийн голлох боловсон хүчин

5.1. В-1 Үндсэн орон тооны ажилтан:

<i>Албан тушаал</i>	<i>Нэр</i>	<i>Тавигдах шаардлага</i>	<i>Чухал шаардлага, ур чадварын хангасан байдал</i>
Ерөнхийлөгч	Г.Алтанзаяа	Боловсрол-дээд, Доктор, профессор	ТМЗН-ийн үүсгэн байгуулагч, 2004 оноос хойш нийгэмлэгийн гүйцэтгэх захирал, ерөнхийлөгчөөр ажиллаж байна. Татварын бүртгэл, нягтлан бодох бүртгэл, санхүү, эдийн засгийн чиглэлээр 22 ном гаргаж, 22 илтгэл, 20 өгүүлэл хэлэлцүүлж, 8 төсөл, судалгааны ажил хийсэн. МУ-ын ТМЗ, МНБ
Гүйцэтгэх захирал /ГЗ/	Ц.Болормаа	Боловсрол-дээд	2005 оноос хойш ТМЗН-т сургалтын менежер, ажлын албаны дарга, ГЗ-аар ажиллаж байна.
Тамгын газрын дарга /ТГ-ын дарга/	Г.Хишигзул	Боловсрол-дээд, магистр	2010 оноос хойш ТМЗН-т нягтлан бодогч, нягтлан бодох бүртгэлийн багш, ТГ-ын даргаар ажиллаж байна. МУ-ын ТМЗ, МНБ
Сургалтын менежер /СМ/	Б.Уранбилэг	Боловсрол-дээд, магистр	2010 оноос хойш ТМЗН-т мэдээлэл технологийн менежер, нягтлан бодох бүртгэлийн багш, СМ, багшаар ажиллаж байна. МУ-ын ТМЗ.
Нягтлан бодогч	Г.Хишигзул	Боловсрол-дээд, магистр	2010 оноос хойш ТМЗН-т нягтлан бодогчоор ажиллаж байна. МУ-ын ТМЗ, МНБ
Мэдээлэл технологийн инженер /МТИ/	Ц.Тулга	Боловсрол-дээд	2015 -2018 оны 9-р сарын 8 өдөр хүртэл ТМЗН-т мэдээлэл МТИ-ээр ажиллаж байсан.
Мэдээлэл технологийн менежер /МТМ/	Ү.Ганболд	Боловсрол-дээд	2016 оноос хойш ТМЗН-т МТМ-ээр ажиллаж байна.

Судалгааны менежер	Ц.Хажидмаа	Боловсрол-дээд	2006 оноос хойш ТМЗН-т Гишүүд, олон нийт, орон нутаг хариуцсан менежер, судалгааны менежерээр ажиллаж байна.
Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан менежер /ГХХАХМ/	Э.Тайвансайхан	Боловсрол-дээд, англи хэлний өндөр мэдлэгтэй	2018 оноос хойш ТМЗН-т Судалгааны төв, ГХХАХМ-ээр ажиллаж байна.
Гишүүд, орон нутгийн салбар хариуцсан менежер /ГОНХМ/	И.Өлзийсайхан	Боловсрол-дээд	2018 оноос хойш ТМЗН-т ГОНХМ-ээр ажиллаж байна.
Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах менежер /ХМОНХМ/	Г.Цэрэндулам	Боловсрол-дээд	2018 оноос хойш ТМЗН-т ажиллаж байна.
Туслах ажилтан	Ш.Даваажаргал	Боловсрол-дээд	2017 оноос хойш ТМЗН-т ажиллаж байна.

5.2. В-2 Орон тооны бүс бүрэлдэхүүн:

Албан тушаал	Тавигдах шаардлага хангасан байдал
Удирдах зөвлөл	ТМЗН-ийн бүх гишүүдийн ээлжит IV их хурлаар /2017 оны 5 дугаар сарын 12 өдрийн/ удирдах ажлын туршлага, багаар ажиллах, манлайлах ур чадвар бүхий ТМЗ гишүүд удирдах зөвлөлд нэрээ дэвшүүлэн санал хураах зарчмаар 11 гишүүн сонгогдсон болно. ТМЗН-ийн УЗ-ийн 2018 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны 007 тоот тогтоолоор Ц. Энхжавхланг УЗ-ийн гишүүнээс чөлөөлж, Ч.Өнөржаргалыг, 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 008 тоот тогтоолоор Б.Бадамцэцэгийг УЗ-ийн гишүүнээс чөлөөлж Б.Авирмэдийг тус тус нөхөн сонгосон болно.
Хяналтын зөвлөл	ТМЗН-ийн бүх гишүүдийн ээлжит IV их хурлаар удирдан зохион байгуулах туршлагатай, багаар ажиллах, манлайлах ур чадвар бүхий татварын мэргэшсэн зөвлөх гишүүд хяналтын зөвлөлд нэрээ дэвшүүлэн санал хураах зарчмаар 5 гишүүн сонгогдсон болно.
Менежментийн хороод	ТМЗН-ийн УЗ-ийн 2017 оны 9 дугаар сарын 27 өдрийн хуралдаанаар удирдан зохион байгуулах туршлагатай, багаар ажиллах, манлайлах ур чадвар бүхий татварын мэргэшсэн зөвлөх гишүүдийг менежментийн хороонд ажиллуулахаар томилсон болно.

6. Хавсралт Г-Үйлчилгээ үзүүлэгчийн үзүүлэх үйлчилгээ болон техник хэрэгсэл

Үйлчилгээ	Үйлчилгээний төрөл	Техник хэрэгсэл
Үйлчилгээ 1	Татварын мэргэшсэн зөвлөхийн эрх олгох шалгалтад бэлтгэх сургалт	<ul style="list-style-type: none"> • <i>Сургалтын анги танхим:</i> 40 суралцагчийн багтаамжтай, ухаалаг самбар, проектор, компьютер зэрэг иж бүрэн хэрэгсэлээр тоноглогдсон. • <i>Сурах бичиг гарын авлага:</i> Сургалтын батлагдсан хөтөлбөрийг агуулсан ном сурах бичиг, гарын авлага • <i>Багшлах боловсон хүчин:</i> Хичээл тус бүрт тухайн
Үйлчилгээ 2	Татварын мэргэшсэн зөвлөхийн эрхийг сунгах тасралтгүй боловсролын сургалт	

<p>Үйлчилгээ 3</p>	<p>Татварын мэргэшсэн зөвлөхийн хуулийн этгээдийг арга зүйн удирдлага, зөвөлгөө мэдээллээр хангах</p>	<p>чиглэлээр ажилласан туршлагатай нарийн мэргэшсэн мэргэжилтэн, их дээд сургуулиудын багш, татварын мэргэшсэн зөвлөхүүд</p> <ul style="list-style-type: none"> • Шалгалтын тестийн санг баяжуулах зорилгоор сургалт судалгааны менежментийн хорооноос хичээл тогтмол заадаг багш нараас хөтөлбөрийн агуулгад нийцсэн тестүүдийг авч, давхардлыг арилган 2018 оныг дуустал бүх тестийг нэгтгэж, “Тестийн эмхтгэл-VI”-номыг хэвлүүлэн суралцагчдын хүртээл болгосон.
<p>Үйлчилгээ 4</p>	<p>Шалгалтад зориулж хичээл тус бүрээр иж бүрэн тестийн сан бүрдүүлэх</p>	

7. ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТУУД


Хавсралт 1: ТМЗ-д эрх олгох шалгалтад бэлтгэх сургалтын мэдээ

Сургалт	Огноо	Суралцагчид	Мэргэшсэн нягтлан бодогч	Нягтлан бодогч	Сураглтад хамрагдаж батламж авсан
№99	2018.02.26-03.17	19	2	14	16
№100	2018.03.20-04.07	22	12	7	19
№101	2018.04.23-05.11	38	13	21	34
№102	2018.04.14-06.16	26	9	16	25
№103	2018.05.28-06.10	23	3	20	23
№104	2018.09.26-10.17	16	5	6	11
№105	2018.10.29-11.17	34	8	12	20
№106	2018.09.29-12.15	57	9	44	53
№107	2018.10.29-11.17	22	9	13	22
Баянхонгор №2	2018.04.11-04.19	14	3	11	14
Багануур дүүрэг №2	2018.05.16-05.24	15	5	10	15
Хөвсгөл №5	2018.04.11-04.19	15	-	15	15
Ховд №7	2018.06.04-06.14	15	1	14	15
Өвөрхангай №5	2018.06.20-06.29	8	1	7	8
Говь-Алтай №2	2018.11.14-11.23	14	6	8	14
		338	78	218	304

Хавсралт 2: ТМЗ-д эрх сунгах сургалтын мэдээ

Сургалт	Хугацаа	ТМЗ гишүүд	Гэрчилгээ сунгагдсан
Анх сунгах	№28	2018.05.01-05.06	47
	№29	2018.10.30-11.05	38
Дахин сунгах	№5	2018.04.27-04.29	42
	№6	2018.11.03-11.05	31
		158	

Хавсралт 3: ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалтын мэдээ /2018 оны эхний хагас жилийн байдлаар/



Хавсралт 4: ТМЗУ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдүүдэд хийсэн хяналт шалгалтын ажлын нэгдсэн тайлан

**“ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ”
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХИЙСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН НЭГДСЭН ТАЙЛАН**

2018.07.06

Сангийн сайдын 2018 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 117 дугаар тушаалаар татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй компаниудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын хэсгийг, удирдамжийн хамтаар батлуулан 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрөөс 7 дугаар сарын 03-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэсэн.

Хяналт шалгалтаар Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллаж байгаа эсэхийг шалгалаа.

Шалгалтын бүрэлдэхүүнд Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар, Татварын ерөнхий газар, Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн холбогдох төлөөлөл орж ажилласан.

Хяналт, шалгалтаар Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа 24 хуулийн этгээд хамрагдсан.

Ажлын хэсэг 4 баг болон ажиллаж тус бүрийн дүгнэлт гаргасны дагуу нэгдсэн дүгнэлтийг гаргасан болно.

Хяналт шалгалтаар дараах зөрчил илэрсэн. Үүнд:

1. Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-т “гурав, түүнээс доошгүй тооны татварын мэргэшсэн зөвлөхтэй байх” гэсэн шаардлагын дагуу шалгахад:
 1. “Глобал Аккаунт ТМЗ” ХХК нь С.Цэвэлмаа, Ш.Төгсбаяр, Б.Нямдаваа гэх 3 татварын мэргэшсэн зөвлөхтэй. Б.Нямдаваа нь 2017 оноос хойш нийгмийн даатгал төлөөгүй, Ш.Төгсбаяр зөвлөхийн шаардлага хангаагүй;
 2. “Интоор финанс ТМЗ” ХХК нь Г.Үүрийнтуяа, Д.Цэвэлмаа гэх 2 татварын мэргэшсэн зөвлөхтэй, Д.Цэвэлмаа зөвлөхийн шаардлага хангаагүй;
 3. “Калкюлус ТМЗ” ХХК нь Ц.Уянга, Б.Баяржавхлан гэх 2 татварын мэргэшсэн зөвлөхтэй;
 4. “Лидерфинанс ТМЗ” ХХК нь Ү.Галмандах, Ү.Цэнгэл, Ц.Цэцэнбилэг, Г.Энхтуяа гэх 4 татварын мэргэшсэн зөвлөхтэй байна. Ү.Цэнгэл, Ц.Цэцэнбилэг, Г.Энхтуяа нар “Лидерфинанс ТМЗ” ХХК-ийн үндсэн орон тооны зөвлөхийн шаардлага хангаагүй;
2. Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6-т “зөвлөх үйлчилгээний ажлын баримтыг хадгалах зориулалтын архивтай байх;” гэсэн шаардлагын дагуу шалгахад:
 - Шалгалтад хамрагдсан 23 хуулийн этгээд нь архивын журам боловсруулан, дотооддоо мөрддөг боловч цаашид архивын журам болон архивын орчин нөхцөлийг сайжруулж, шинэчилэх шаардлагатай байгаа нь шалгалтын явцад илэрсэн болно.
3. Сангийн сайдын сайдын 2018 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 171 дугаар тушаалаар “Даймондтакс ТМЗ” ХХК-ийн нэр “Файнаншил про такс ТМЗ” ХХК болж өөрчлөгдсөн бөгөөд

зохих өөрчлөлтийг улсын бүртгэлд хийлгүүлээгүй байсан. Мөн ажлын байр нүүж, үйл ажиллагаа жигдрээгүй байсан болно.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ:

1. Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлд заасныг зөрчсөн, ханган ажиллаагүй, хангахгүй байгаа нь тогтоогдсон “Глобал аккаунт ТМЗ” ХХК, “Интоор финанс ТМЗ” ХХК, “Калкюлус ТМЗ” ХХК, “Лидерфинанс ТМЗ” ХХК-иудын татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлэх;
2. Нийт шалгалтад хамрагдсан татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээдүүдэд Үндэсний архивын газрын даргын 2007 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 59 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох үүрэг даалгавар өгөх;
3. “Файнаншил про такс ТМЗ” ХХК-ийг дараагийн хяналт, шалгалтад хамруулах;



Хавсралт 5: ТМЗ-ийн эрхийг хүчингүй болгох тухай

МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 577

Улаанбаатар хот

Эрх олгох, сунгах, хүчингүй
болгох тухай

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, Шалгалтын бүрэлдэхүүний 2017 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


Нэг. Татварын мэргэшсэн зөвлөхийн эрх олгох шалгалтанд тэнцсэн 1 дүгээр хавсралтад заасан нэр бүхий 30 /гуч/ нягтлан бодогчдод татварын мэргэшсэн зөвлөхийн эрхийг 3 жилийн хугацаатай олгосугай.

Хоёр. Татварын мэргэшсэн зөвлөхийн эрх сунгах шалгалтад тэнцсэн 2 дугаар хавсралтад заасан нэр бүхий 115 /нэг зуун арван тав/ татварын мэргэшсэн зөвлөхийн эрхийг сунгасугай.

Гурав. Татварын мэргэшсэн зөвлөхийн эрхийн хугацаа нь дууссан 3 дугаар хавсралтад заасан нэр бүхий 12 /арван хоёр/ татварын мэргэшсэн зөвлөхийн эрхийг хүчингүй болгосугай.

Дөрөв. Татварын мэргэшсэн зөвлөхийн эрх авсан, эрхийн хугацаагаа сунгуулсан татварын мэргэшсэн зөвлөхийг хуулийн дагуу тангараг өргүүлэх ажиллагааг зохион байгуулахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга /Г.Түвдэндорж/, Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг /Г.Алтанзаяа/-т тус тус даалгасугай.

Тав. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга /Н.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.



Ч.ХҮРЭЛБААТАР

Хавсралт 5: ТМЗ-ийн эрхийг хүчингүйд тооцох



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 10 сарын 3 өдөр

Дугаар 239

Улаанбаатар хот

□ Эрх хүчингүй болгох тухай □

Монгол улсын засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Татварын мэргэшсэн зөвлөхийн ёс зүйн дүрмийг ноцтой зөрчсөн нь тогтоогдсон Ц.Уянгын татварын мэргэшсэн зөвлөхийн эрхийг хүчингүй болгосугай.

2. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Ч.Чимидсүрэн/-т үүрэг болгосугай.

Ч.ХҮРЭЛБААТАР

0 0496

Хавсралт 5: ТМЗ-ийн эрхийг хүчингүйд тооцох



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 10 сарын 22 өдөр

Дугаар 248


Улаанбаатар хот

Г Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дэх хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 14 дүгээр зүйлийн 14.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сангийн сайдын 2018 оны 182 дугаар тушаалаар татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл нь 3 сарын хугацаатай түдгэлзсэн, түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй "Интоор финанс ТМЗ" ХХК, "Калкюлүс ТМЗ" ХХК-иудын татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс хүчингүй болгосугай.

2. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Ч.Чимидсүрэн/-т үүрэг болгосугай



Ч.ХҮРЭЛБААТАР

Хавсралт 6: Шалгалтын тестийн сан бүрдүүлэх, татварын чиглэлийн олон улсын бичиг баримт орчуулах, тайлбарлах, зөвлөмж боловсруулах, судалгааны ажил хэрэгжүүлэх



TATVAR & БИЗНЕС
ТӨРИЙН ДЭГ ТАТВАР ХЭЛ, ТАТВАР ХЭЛ ДЭГ ТӨРИЙН ДЭГ

"BEPS Mongolia-2017"
СЭДЭВТ ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛЭЭНИЙ ХУРАЛ БОЛНО

ISSI
INTERNATIONAL STANDARDIZATION SOCIETY

BEPS
BEPS IS AN OCEAN

ОЛОН УЛСЫН ТАТВАРЫН СИСТЕМИЙН ШАХИРДАГ

"ТАТВАРЫН СУУРИЙГ БАГАСГАЖ АШГИЙГ ЗУВЧУУЛГАЙ" АСУУЛАЛТАЙ ТЭМЦЭХ 15 АЖИЛАГАА

1 2 3 4 5 6 ... 15

НИЙСЛЭЛ ХОТЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН СУДАЛГАА

Орлого

ISSN 2519-1518

TAX & BUSINESS
MONGOLIA'S TAX & BUSINESS

ORIGINAL SIN: IS MONGOLIA FACING AN EXTERNAL DEBT CRISIS?
Batsukh Halbar

CRISIS JUST AHEAD

SOME ISSUES ON LONG-TERM FINANCING IN MONGOLIA
Danzanbayar Yandagombo

BEPS AS EXPLAINED BY OECD
BEPS Minimum Standards

TAX RISK PROBLEM
Altanzaya Bayan

RISK MANAGEMENT

ISSN 2519-1518

TATVAR & БИЗНЕС
ТӨРИЙН ДЭГ ТАТВАР ХЭЛ, ТАТВАР ХЭЛ ДЭГ ТӨРИЙН ДЭГ

MONGOLIA'S TAX & BUSINESS GUIDE
TAXATION FOR BUSINESS

JOURNEY FROM FLAT TAX TO PROGRESSIVE TAX

DEVELOPMENT OF TRANSFER PRICING DOCUMENTATION RULES AND LESSONS FOR MONGOLIA

DEBT IN MONGOLIAN MADE CAPITALISM

THE MARGINAL WELFARE BURDEN OF MONGOLIA'S TAX SYSTEM

WHAT TAX INSPECTORS WITHOUT BORDERS?

ISSN 2519-1518

MONGOLIA'S TAX & BUSINESS GUIDE
TAXATION FOR BUSINESS

JOURNEY FROM FLAT TAX TO PROGRESSIVE TAX

DEVELOPMENT OF TRANSFER PRICING DOCUMENTATION RULES AND LESSONS FOR MONGOLIA

DEBT IN MONGOLIAN MADE CAPITALISM

THE MARGINAL WELFARE BURDEN OF MONGOLIA'S TAX SYSTEM

WHAT TAX INSPECTORS WITHOUT BORDERS?

ISSN 2519-1518

TATVAR & БИЗНЕС
ТӨРИЙН ДЭГ ТАТВАР ХЭЛ, ТАТВАР ХЭЛ ДЭГ ТӨРИЙН ДЭГ

TAX & BUSINESS
MONGOLIA'S TAX & BUSINESS

TAX GLOBALIZATION IN MONGOLIA

Улаанбаатар хот 2018 он

TAX & BUSINESS
MONGOLIA'S TAX & BUSINESS

TAX GLOBALIZATION IN MONGOLIA

Улаанбаатар хот 2018 он

STUDY ON TAX EVASION PSYCHOLOGY

Introduction

1. PERCEPTION OF INDIVIDUALS AND BUSINESS

1.1 Psychology of individuals and business

1.2 Psychological factors

2. STUDY ON PSYCHOLOGY OF TAX EVASION

2.1 Study on perception and evasion results

2.2 Study on perception and evasion results

A Survey Study on the perception and evasion of taxpayers



Introduction

1. Survey

2. Results

3. Conclusion

Хавсралт 7: ТМЗ-ийн эрхийг сунгах тасралтгүй боловсролын сургалт



Хавсралт 8:

ТМЗҮ ЭРХЭЛЖ БҮЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДҮҮДИЙН УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН

ТМЗН-ийн Удирдах ажилтны зөвлөгөөн тавдугаар сарын 2-ны өдөр Чингис зочид буудалд амжилттай зохион байгуулагдлаа. Хуралдаанаар татварын хуулийн хэрэгжилтийг хангах, ТМЗН-ийн салбарын үйл ажиллагааг өргөтгөх болон олон улсын татварын системийн шинэчлэл зэрэг олон асуудлыг хэлэлцснээс гадна 9 дүгээр сарын 12-14-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдах “АОТСА-2018” олон улсын хурлын зохион байгуулалтын талаар зөвлөлдөв.



**Татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээ
“ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ- 2018”-ын тайлан мэдээ**

Монгол Улсын Сангийн Яамнаас санаачлан зохион байгуулсан ТМЗҮ- ЗӨВЛӨЛДӨХ-2018 уулзалтыг 2018-оны 11-р сарын 21-ний өдөр Сангийн Яамны “Түшээ” танхим-д амжилттай зохион байгууллаа. Уулзалтад төр, мэргэжлийн байгууллагаас 7 төлөөлөл, ТМЗҮ эрхлэгч хуулийн этгээдийн төлөөлөл- 43, ТМЗН-ийн Удирдах зөвлөлийн гишүүдээс 6, Хяналтын зөвлөлөөс 1, ТМЗ гишүүдийн төлөөлөл, Нийгэмлэгийн ажлын алба бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож, нийтдээ 70 гаруй хүн хамрагдсан томоохон хэмжээний уулзалт боллоо. Зөвлөлдөх уулзалтыг нээж СЯ-ны НБББГ-ын дарга Ч.Чимидсүрэн, ТЕГ-ын дэд дарга Д.Заяабал нар үг хэллээ.

Уг уулзалтад Сангийн яамны Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Газрын дарга Ч.Чимидсүрэн “НБББГ-ын чиг үүрэг, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн яам ТМЗ нийгэмлэгийн хамтын ажиллагаа, цаашдын зорилго зорилтын талаар”, Татварын ерөнхий газрын татварын улсын ахлах байцаагч Б.Галбадрах “Татварын тогтолцоонд татварын үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг: Азийн орнуудын туршилага” сэдвээр илтгэл тавьж, орон орны туршлагаас танилцуулан, Монгол улсад ТМЗ үйлчилгээ хэрхэн хөгжиж буй талаар хэлэлцэж, ТМЗ нийгэмлэгийн ерөнхийлөгч Г.Алтанзаяа “Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний зохицуулалт ба өнөөгийн байдал, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тусгай зөвшөөрөл сэдвээр” ТМЗН-ийн удирдах зөвлөлийн гишүүн Ү.Галмандах “Татварын албаны үйл ажиллагаанд Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ дэмжлэг үзүүлэх нь сэдвээр” ТМЗН-ийн ЗҮМХ-ны дарга Р.Хишигнэмэх “ТМЗ үйлчилгээний хөгжил, сайжруулах талаар” илтгэл тавьж оролцлоо.

Илтгэлийн дараа сэдэв тус бүрээр буюу /Хууль эрх зүйн асуудал, Төр, мэргэжлийн байгууллагатай холбоотой асуудал, ТМЗХЭ-тэй холбоотой асуудал, Гишүүдтэй холбоотой асуудал, Зохицуулагдаагүй орхигдож буй асуудал/-ын хүрээнд оролцогчид баг болон ажиллаж хэлэлцүүлэг өрнүүлэн, шийдвэрлэх арга замыг хамтдаа хэлэлцэн, танилцуулга хийлээ. Баг бүрийг ахалж ТМЗН-ийн Зөвлөх үйлчилгээ менежментийн хорооны гишүүд ажилласан. Мөн уулзалтын явцад оролцогч болон төрийн байгууллагын хооронд нээлттэй асуулт, хариулт явагдлаа.

**ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТЫН ШИЙДВЭР-ДҮГНЭЛТ
САНГИЙН ЯАМ:**

- ТМЗҮйлчилгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай
- -Ажлын хэсэг байгуулах
- -ТМЗҮ-г тусгай зөвшөөрөлгүй хэрэгжүүлж байгаа этгээдүүдэд хариуцлага тооцох ажлыг шат дараатай авч хэрэгжүүлэх

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР:

- Татварын хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор ТМЗ байгууллагын үйл ажиллагааг стандартчилахад төрөөс дэмжлэг үзүүлэх
- ТМЗҮйлчилгээ эрхлэхэд зориулсан тусгай бодлогоор хангаж, нэвтрүүлэх
- Хамтын ажиллагааг өргөжүүлэх
- Татварын байцаагчийн ёс зүйн асуудлыг сайжруулах
- ТМЗ-үүдийг тоон гарын үсэг олгох тогтолцоог нэвтрүүлэх

ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН НИЙГЭМЛЭГ:

- ЖДҮ эрхлэгч татвар төлөгчдөд ТМЗҮ-г хүргэх замаар татварын тайлангийн ирцийг нэмэгдүүлэх
- Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах
- ТМЗҮ-ний оруулж буй хувь нэмрийн талаарх судалгааг тогтмолжуулах.



Хавсралт 9: АОТСА -2018 Mongolia ОУ-ын Татварын чуулган



ОЛОН УЛСЫН ТАТВАРЫН ЧУУЛГАНЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ ХУРААНГУЙ ТАЙЛАН МЭДЭЭ

ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БАГ:

“АОТСА 2018 MONGOLIA” олон улсын татварын чуулганыг зохион байгуулах ажлын хэсэг:

- Ажлын хэсгийн ахлагч: А.Тамир /ТМЗН-ийн УЗ-ийн гишүүн/
- Ерөнхий нарийн бичиг: Ж.Энхзул /ТМЗН-ийн УЗ-ийн гишүүн/
- Ерөнхий зохицуулагч: Ц.Болормаа /ТМЗН-ийн Гүйцэтгэх захирал/

Ерөнхий зохион байгуулалтын ажлын хэсгийн ахлагч:

- Ц.Болормаа /ТМЗН-ийн Гүйцэтгэх захирал/
- Х.Тунгалагмаа /ТМЗН-ийн ССМХ-ны дарга/

Санхүүжилт, санхүүгийн ажлын хэсгийн ахлагч

- Г.Хишигзул /ТМЗН-ийн Тамгын газрын дарга/
- А.Тамир /ТМЗН-ийн УЗ-ийн гишүүн/

Гадаад харилцаа, бүртгэл, илтгэл, хэлэлцүүлэг зохион байгуулалтын ажлын хэсгийн ахлагч

- Ж.Энхзул /ТМЗН-ийн УЗ-ийн гишүүн/
- Г.Алтанзаяа /ТМЗН-ийн УЗ-ийн дарга бөгөөд ерөнхийлөгч/

Олон нийт, хэвлэл мэдээлэлтэй харилцах, сурталчилгаа, маркетингийн ажлын хэсгийн ахлагч

- Р.Хишигнэмэх /ТМЗН-ийн ЗҮМХ-ны дарга /
- Г.Норжмаа/ТМЗН-ийн ХЗ-ийн гишүүн гишүүн/

ХАМТЫН АЖИЛЛАГАА:

- **Хамтран ажиллах хүсэлт:** Төр хувийн хэвшлийн байгууллагуудад давхардсан тоогоор 93 удаа “АОТСА 2018 MONGOLIA” олон улсын татварын чуулганыг зохион байгуулахад хамтран ажиллах санал тавьсан байна. Үүнээс
 - 25 удаа – Төрийн байгууллагад / СЯ, ГХЯ, ТЕГ, ЦЕГ, ГИХГ/
 - 43 удаа – ТМЗ хуулийн этгээдүүдэд
 - 25 удаа - Бусад аж ахуйн нэгж байгууллагад
- **Гэрээ:** Олон улсын чуулган зохион байгуулах ажлын хүрээнд 20 гаруй албан байгууллага, хувь хүмүүстэй гэрээ байгуулан ажиллаа. /Шангри-Ла Улаанбаатар зочид буудал, ХХБ, Флай саунд ХХК, Корпрэйт зочид буудал, Blue sky зочид буудал, Глобал Ивэнт ХХК, Best shoes ХХК, Д.Халиун Синхрон орчуулга, Чингис зочид буудал, Ганхуяг Хөтлөгч, Гэр мэдиа ХХК, М Жи Си Тур ХХК.../
- **Ивээн тэтгэгчид:** Олон Улсын татварын чуулганыг 29 байгууллага ивээн тэтгэж ажиллаа.
 - Платинум ивээн тэтгэгч - 3
 - Гоулд ивээн тэтгэгч - 3
 - Силвер ивээн тэтгэгч – 2
 - Бронзе ивээн тэтгэгч - 10
 - Дэмжигч байгууллага - 11

ТӨЛӨВЛӨГӨӨ:

Зохион байгуулалтын үйл ажиллагааг Ерөнхий төлөвлөгөө, нарийвчилсан төлөвлөгөөгөөр гарган хуваарилж, гүйцэтгэл биелэлтийг тогтмол хянаж, ажлын хэсгээрээ зөвшилцөж ажилласан. Ойролцоогоор 130 орчим ажлыг төлөвлөн, гүйцэтгэлээр давуулан биелүүлсэн байна. Олон улсын татвар, татварын бодлого 21-р зуунд сургалт, Татварын зөвлөхүүдийн глобал платформ /GTAP/-д гарын үсэг зурах ёслол, Олон улсын татварын хурал зэрэгт тусгайлан нарийвчилсан төлөвлөгөө гаргаж ажилласан бөгөөд вэб сайт, орчуулга, урлаг соёлын арга хэмжээ, хэвлэл мэдээлэл сурталчилгаа зэрэг ажил бүрийг анхаарч ажилласан.

ИЛТГЭЛ МАТЕРИАЛЫН ОРЧУУЛГА

Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн гишүүд болон гишүүн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ОРЧУУЛГЫН БАГ ажиллаж 16 илтгэл, сургалтын материал, АОТСА сэтгүүлд тавигдсан материалуудыг орчуулсан байна.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГАА

- 13 телевизээр 21 удаа мэдээ ярилцлага
- 23 сайтаар 29 удаа мэдээ ярилцлага
- 2 сонинд 2 удаа ярилцлага, нийтлэл
- 4 ФМ-ээр 1 удаа мэдээ, шторк
- www.cpta.mn сайтаар 27 удаа мэдээ ярилцлага
- www.aotca2018mongolia.mn сайтаар 7 удаа мэдээ цацаж олон нийтэд түгээлээ.



ОЛОН УЛСЫН ТАТВАР, ТАТВАРЫН БОДЛОГО 21-Р ЗУУНД СУРГАЛТ

Анх 80-100 хүнийг хамруулахаар төлөвлөж байсан ч сургалтад 300 орчим хүнийг хамруулж, өндөр түвшинд зохион байгуулсан.



“ГТАР” ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ ЁСЛОЛ

“ТАТВАРЫН ЗӨВЛӨХҮҮДИЙН ГЛОБАЛ ПЛАТФОРМ” байгуулж буйгаа тунхаглан гарын үсэг зурах ёслолын ажиллагааны үеэр 11 телевиз, 8 сайт, 1 радио мэдээлэл түгээсэн.



VIP СОСКТАЙЛ ХҮЛЭЭН АВАЛТ

Ивээн тэтгэгчид болон Гадны хүндэт зочид төлөөлөгчиддөө зориулж VIP СОСКТАЙЛ хүлээн авалтыг зохион байгуулхын зэрэгцээ спонсорууддаа талархал илэрхийлж цом, гарын бэлэг, сургалтад суух эрхийн бичиг олгосон.



“АОТСА 2018 MONGOLIA” ОЛОН УЛСЫН ТАТВАРЫН ЧУУЛГАН

“АОТСА 2018 MONGOLIA” Олон улсын татварын чуулганд нийт 542 зочид төлөөлөгчид хамрагдсны гадаадын -282, дотоодын -260 зочид төлөөгчид оролцсон байна.



АОТСА-ны удирдлагууд болон чуулганд оролцогсад “АОТСА 2018 MONGOLIA” олон улсын татварын чуулганыг өндөр хэмжээнд зохион байгуулсан гэж дүгнэсэн.

АЧ ХОЛБОГДОЛ, ҮР ДҮН:

- ✓ Дэлхийн татварын зөвлөхүүдийг нэгтгэсэн
- ✓ Монгол Улсын нэр хүндийг олон улсын төвшинд өргөсөн
- ✓ Монгол Улсын Татварын Мэргэшсэн Зөвлөхийн Нийгэмлэгийн чансааг таниулсан
- ✓ Монголын санхүү, татвар, бүртгэлийн мэргэжилтэнгүүдийг шинэ мэдлэг мэдээллээр цэнэглэсэн
- ✓ Дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн илтгэгчдийг нэг дор цуглуулж чадсан
- ✓ Монгол улсад тодорхой хэмжээний мөнгөн урсгалыг оруулсан
- ✓ АОТСА-ын шинэ удирдлагыг сонгох түүхэн цаг үеийг гэрчилсэн
- ✓ Хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлсэн
- ✓ Монгол Японы хамтарсан сайн дурын нийгэмлэг байгуулсан
- ✓ Бизнес түншлэлийг өргөжүүлсэн


Хавсралт 10:

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗРААС ТМЗҮ ҮЗҮҮЛЖ БҮЙ ААНЬ-ЫН СУДАЛГАА

/Тайлангаа ирүүлээгүй татвар төлөгчидтэй холбогдсон байдал/

Д/д	Дүүрэг	Нийт ААН	Ярьсан: /Үүнээс/				
			Ярьсан:	Зөвлөгөө авах	Эргээд холбогдох	Татан буулгах	Утас буруу, ашиглалтад байхгүй, холбогдоогүй
1	Баянгол	11,007	1,508	43	125	85	1255
2	Баянзүрх	11,920	448	8	82	20	338
3	Чингэлтэй	7,329	76	8	13	2	53
4	Сонгинохайрхан	6,612	73	1	2	3	67
5	Хан-Уул	5,161	75	3	4	1	67
	Нийт	42,029	2,180	63	226	111	1780
	Хувь		100%	3%	10%	5%	82%

/Тайлан мэдээ/



ТАТВАРЫН ХУУЛИЙГ ХЭН САЙН МЭДЭХ ВЭ? ОЮУТНЫ ТЭМЦЭЭНИЙ ТАЙЛАН

Сэдэв: Е-баримтын хэрэгжилт зах худалдааны төвд

Татвар төлөгчдийн өдрийг тохиолдуулан татвар, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр суралцагч их, дээд сургуулийн оюутнуудын дунд зохион байгуулдаг “Татварын хуулийг хэн сайн мэдэх вэ?” уралдаант тэмцээн 5 дугаар сарын 9-11-ний хооронд гурван өдөр амжилттай зохион байгуулагдлаа. 12 дахь жилдээ зохион байгуулдсан тус тэмцээн “Е-Баримтын хэрэгжилт зах, худалдааны төвүүдэд” сэдвийн хүрээнд 5 сарын 9, 10-нд Нарантуул олон улсын худалдааны төв дээр судалгаа, сурталчилгааны өдөрлөг, 5 сарын 11-нд ТЕГ-т онолын мэдлэг сорих болон асуулт хариултын төрлөөр явагдсан юм.

Ерөнхий зохион байгуулагч: “Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг”

Хамтран зохион байгуулагч: Татварын ерөнхий газар, Нийслэлийн татварын газар, Хэрэглэгчийн систем нийлүүлэгчдийн холбоо

Оролцогч багууд: “Тэмүүлэл” баг /МУИС-Бизнесийн сургууль/, “Инфинити” баг /МУИС-Бизнесийн сургууль/, “татварын титанууд” баг /мандах их сургууль/, “мандах такс” баг /мандах их сургууль/, “Эрдэм” баг /Улаанбаатар Эрдэм их сургууль/, “Мэргэн” баг /Олон улсын эдийн засаг бизнесийн дээд сургууль/, “Шинэчлэл” баг /Олон улсын Улаанбаатар их сургууль/, “Зургаан бэрх” баг /ХААИС/

Нэгдүгээр шат: Нарантуул оу-ын худалдааны төвд /5 сарын 9,10/

Тэмцээнд оролцож буй багууд тэмцээний эхний өдөр “Нарантуул” олон улсын худалдааны төвд худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжид Е-Баримтыг хэрэгжүүлээгүйгээс үүсэх эрсдэл, хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласнаар хүртэх үр өгөөжийг таниулж сурталчлах, зөрчлийн хуулийн холбогдох хэсгийг танилцуулах зэрэг Е-Баримтыг хэрэгжүүлэхтэй холбоотой даалгавруудыг гүйцэтгэлээ. Мөн худалдаа эрхлэгчдээс цаашид ямар байдлаар Е-баримтыг хэрэгжүүлэх сонирхолтой байгаа талаарх судалгааг авч, зах дээр үйл ажилагаа эрхлэгчдийг хамруулсан олон тэмцээн уралдаан, идэвхижүүлэлтийн ажлыг санаачлан зохион байгууллаа.



Сурталчилгааны хоёр дахь өдөр буюу тавдугаар сарын 10-нд Хэрэглэгчийн систем нийлүүлэгчдийн холбооны гишүүн байгууллагууд Нарантуул зах дээр Е-баримт хэвлэх төхөөрөмжүүдээ танилцуулах үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан. Уг үзэсгэлэн худалдаанд ТЕГ, НТГ, дүүргийн татварын хэлтсүүдийн төлөөлөл оролцсон. Худалдаа эрхлэгчдэд Е-баримтыг хэрэгжүүлэх тухай эерэг ойлголтыг өгөхөөс гадна дүүргийн татварын албадууд АХА, Та битгий уурлаарай тэмцээнүүдийг зохион байгуулж, урлаг соёлын үзүүлбэрүүд явагдсан.



Хоёрдугаар шат: Татварын ерөнхий газарт /5 сарын 11/

2-р шатны тэмцээнд:

1. Багийн мэндчилгээ
2. Е-баримтын хэрэгжилтийг сайжруулах нь сэдэвт тайлан илтгэл
3. Багийн асуулт хариултын тэмцээн
4. Бодлого бодох тэмцээн
5. Багийн ахлагч нарын тэмцээн
6. Зурагт хуудасны тайлбар гэсэн зургаан хэсэгтэй байсан



Тэмцээний шүүх бүрэлдэхүүнд:

Д.Цогзолмаа /ТЕГ-ын Татвар төлөгчтэй харилцах газрын дарга/

Т.Энхтайван /НТГ-ын Хяналт шалгалтын хэлтсийн дарга/

Ц.Болормаа /ТМЗН-ийн гүйцэтгэх захирал/,

Х.Тунгалагмаа /ТМЗН-ийн Сургалт, судалгаа менежментийн хорооны дарга/

П.Баярсайхан /ХСНХ-ны Удирдах зөвлөлийн дарга/



Шагнал гардуулалт

Тэмцээний шилдэг оролцогчдод шагнал гардуулах үйл ажиллагааг 5 сарын 30-нд ТЕГ-ын Татвар төлөгчдөд үйлчлэх танхимд зохион байгуулсан. Шагнал гардуулах үйл ажиллагаанд ТЕГ-ын ТТХГ-ын дарга Д.Цогзолмаа, НТГ-ын ТТХХ-ийн дарга Х.Уранчимэг, ТМЗН-ийн гишүүд олон нийттэй харилцах менежер Ц.Хажидмаа нар оролцож шагналыг гардуулан өглөө.

Нэгдүгээр байрт МУИС-ийн Т.Мөнхзаяа багштай “Инфинити”,

Хоёрдугаар байрт МУИС-ийн Л.Хишигбаяр багштай “Тэмүүлэл”,

Гуравдугаар байрт Мандах их сургуулийн М.Энхсүрэн багштай “Татварын титанууд” баг тус тус шалгарлаа.



**ДЭМЖИГЧ
БАЙГУУЛЛАГА:**



**ХАМТРАН ЗОХИОН
БАЙГУУЛАГЧ:**



**САНААЧЛАН ЗОХИОН
БАЙГУУЛАГЧ:**



Татварын бүртгэл

улсын V олимпиад - 2018

ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ЗОРИЛГО

Оролцогчдын татвар, санхүү, нягтлан бодох бүртгэлийн талаарх мэдлэг ур чадварыг сорих, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, сурталчилан таниулахад оршино.

ХАМРАХ ХҮРЭЭ

I БҮЛЭГ
- Нягтлан бодогч, Татварын улсын байцаагч

II БҮЛЭГ
- Их, дээд сургуулийн оюутан

I үе шат:
2018 оны 11-р сарын 23-ны өдөр 14:00 - 16:30 цагт
/цахимаар/

II үе шат:
2018 оны 11-р сарын 30-ны өдөр 13:00 - 18:00 цагт
/танхимд/

ШАГНАЛ

<p>I БҮЛЭГ /НЯГТЛАН БОДОГЧ,ТУЫ/</p> <p>2 дугаар шатанд шалгарч үлдсэн хүн бүрт Baaz системийг ашиглах 60000 төгрөгийн эрхийн бичиг олгоно.</p> <p>I байр: Өргөмжлөл, 800,000 төгрөг</p> <p>II байр: Өргөмжлөл, 500,000 төгрөг</p> <p>Тусгай байр: ТМЗН-с зохион байгуулагдаж буй төлбөртэй сургалтад суух 200,000 төгрөгийн эрхийн бичиг</p>	<p>II БҮЛЭГ /ОЮУТАН/</p> <p>2 дугаар шатанд шалгарч үлдсэн хүн бүрт Baaz системийг ашиглах 60000 төгрөгийн эрхийн бичиг олгоно.</p> <p>I байр: Өргөмжлөл, 500,000 төгрөг</p> <p>II байр: Өргөмжлөл, 300,000 төгрөг</p> <p>Тусгай байр: ТМЗН-с зохион байгуулагдаж буй төлбөртэй сургалтад суух 100 000 төгрөгийн эрхийн бичиг</p>
--	---

БҮРТГЭЛ:
Оролцогчид 2018.11.05 - 11.22-ны 18:00 цаг хүртэл www.baaz.mn вэб сайтад бүртгүүлээрэй

ХОЛБОО БАРИХ
Зохион байгуулалттай холбоотой мэдээллийг - 76118989,
Бүртгэлтэй холбоотой мэдээллийг - 70007001
Цахим хуудас: www.cpta.mn, www.baaz.mn

Олимпиадын I шат: Нэгдүгээр шатны шалгаруулалт 2018 оны 11 дүгээр сарын 23-нд www.baaz.mn сайтаар онлайнаар зохион байгуулагдлаа. Нэгдүгээр шатанд:

Оюутан бүлэгт – 163 оюутан залуус

Нягтлан бодогч, татварын улсын байцаагч бүлэгт - 105 нягтлан бодогч нийтдээ 268 хүн оролцлоо.

← → ↻ <https://edu.baaz.mn>

Apps My Drive - Google Dr МТШХХГазар

BAAZ

Онлайн тэмцээн 2018

- ✓ Бүртгэл
- ✓ 1-р шат (Онлайн)
- ☑ 2-р шат (Танхимд)

ТАТВАРЫН БҮРТГЭЛ ОНЛАЙН ОЛИМПИАД 2018 (1-р шат)

1. Татварын бүртгэл 2018 (Нягтлан) (GS0120)

Асуултын Тоо 100

Үргэлжлэх Хугацаа (Минут) 150

Тест бөглөх

Эхний онлайн шалгаруулалтаас бүлэг тус бүрт 20, 20 оролцогч шалгарч 2-р шатанд оролцох эрхтэй болсноос гадна Бааз системийг ашиглах 60 мянган төгрөгийн эрхийн картын эзэд болсон юм.

Олимпиадын II шат: Хоёрдугаар шатны шалгаруулалт танхимын хэлбэрээр 2018 оны 11 дүгээр сарын 30-нд Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн хичээлийн II байранд зохион байгуулагдлаа.



Тэмцээний II шатанд нягтлан бодох бүлэгт 15, оюутан бүлэгт 18 хүн оролцсоноос:

Нягтлан бодогч бүлэгт:

I байр - Батбаяр овогтой Ганбагана /Мандах ИС-ийн багш/

II байр - Батбаяр овогтой Бат-Амгалан /СЭЗИС-ийн багш/

Тусгай байр – Далхжав овогтой Амирдийбазар /ОБ пластик ХХК-ийн нягтлан/

Оюутан бүлэгт:

I байр – Наранбаатар овогтой Ариунзаяа /СЭЗИС-ийн оюутан/

II байр - Мөнхжаргал овогтой Энхжаргал /СЭЗИС-ийн оюутан/

Тусгай байр – Ганбат овогтой Хүслэн /СЭЗИС-ийн оюутан/ нар байр эзлэв.

Шагнал гардуулалт:

Шагнал гардуулах ёслолын ажиллагааг 2018 оны 12 дугаар сарын 5-нд Сангийн яамны түшээ танхимд зохион байгуулав. Шагнал гардуулах ёслолд СЯ-ны НБББГ-ын ахлах мэргэжилтэн Б.Болормаа, ТМЗ нийгэмлэгийн гүйцэтгэх захирал Ц.Болормаа, ССМХ-ны дарга Х.Тунгалагмаа, Тамгын газрын дарга Г.Хишигзул, Төөгий такс ТМЗ ХХК-ийн менежер Э.Нямдэлгэр нар оролцож шилдэг оролцогчдын шагналыг гардуулан өглөө.



ТМЗ-ИЙН ТАНГАРАГ ӨРГӨХ ЁСЛОЛ

Мэргэжлийн ёс зүй, нэр хүндийг өндөрт өргөж явахыг батлан тангараглах “Тангараг өргөх ёслол”-ын арга хэмжээг жилд 2 удаа ТМЗ-ийн эрх олгох, эрхийг сунгах шалгалтад тэнцсэн ТМЗ гишүүд өргөдөг бөгөөд 2018 оны эхний хагас жилд зохион байгуулагдсан Тангараг өргөх ёслолын арга хэмжээг 6 дугаар сарын 28-ны өдөр Сангийн яамны Хүндэтгэлийн танхимд зохион байгууллаа. Эхний хагас жилийн байдлаар 34 нягтлан бодогч шинээр ТМЗ эрх авч, 89 нягтлан бодогч ТМЗ-ийн эрхээ сунгуулан ТМЗ-ийн ТАНГАРАГИЙГ өргөсөн байна.



*Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 1-р сарын 31-ний
өдрийн 005 тогтоолын 2-р хавсралт*

ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН НИЙГЭМЛЭГИЙН ЁС ЗҮЙ, ХЯНАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмаар “Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг” /цаашид “ТМЗН” гэх/-ийн Ёс зүй, хяналтын менежментийн хороо /цаашид “ЁЗХМХ” “Хороо” гэх/ -ны үйл ажиллагааг явуулах, шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавих, татварын мэргэшсэн зөвлөх /цаашид гишүүд гэх/, татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээ эрхэлж буй хуулийн этгээд гишүүн байгууллага /цаашид гишүүн байгууллага гэх/-уудын ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангуулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийн ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авч, холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2 ЁЗХМХ-г ТМЗН-ийн дүрмийн дагуу эрх олгогдсоны үндсэн дээр үүсгэн байгуулна.
- 1.3 ЁЗХМХ нь үйл ажиллагаандаа шударга, ил тод, хараат бус байх, гишүүд санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, цөөнхийг сонсож, олонхийн шийдвэрийг хүндэтгэх зарчмыг баримтлана.
- 1.4 ЁЗХМХ-ны ажиллах журмын хууль зүйн үндэс нь Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хууль (цаашид “ТМЗҮТХ” гэх), ТМЗН-ийн дүрэм, Татварын мэргэшсэн зөвлөх /цаашид ТМЗ гэх/-ийн Ёс зүйн дүрэм болон эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад дүрэм, журам байх ба ЁЗХМХ нь үйл ажиллагаагаа энэхүү журмыг баримтлан явуулна.

Хоёр. ЁЗХМХ -ны чиг үүрэг

- 2.1 ЁЗХМХ–ны чиг үүрэг нь ТМЗН-ийн дүрэмд заасны дагуу Гүйцэтгэх албаны үйл ажиллагаанд менежментийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх зорилготой байх бөгөөд энэ журмын 1.1-т заасан заалтын хүрээнд гишүүд болон гишүүн байгууллагын ёс зүйтэй холбоотой асуудлыг хянан шийдвэрлэх, тэдгээрийн үүргийн биелэлтийг хангуулахад туслалцаа үзүүлнэ.
- 2.2 ЁЗХМХ нь ТМЗН-ийн дүрмийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь заалтад заасан ерөнхий чиг үүрэг, 13 дугаар зүйлийн 13.10 дахь заалтад заасан тусгай чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Гурав. ЁЗХМХ-ны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны хэлбэр

- 3.1 ЁЗХМХ нь 9-11 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.
- 3.2 ЁЗХМХ -ны даргыг Удирдах Зөвлөлийн хуралдааны шийдвэрээр томилно.
 - 3.2.1 ЁЗХМХ-ны дарга нь:
 - ✓ хорооны хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, удирдан чиглүүлэх, гишүүдийн ажил үүргийг хуваарилах, гүйцэтгэх ажлын хэсэг

- ✓ томилох, хэрэгжилтэд хяналт тавих;
 - ✓ хорооны ажлын үр дүн болон гаргасан дүгнэлтийн бодит байдлыг хариуцах,
 - ✓ шийдвэрлэх асуудал болон үр дүнг удирдах зөвлөлд танилцуулах зэрэг үндсэн чиг үүрэгтэй байна.
 - ✓ хорооны дарга хорооны хуралдаан /цаашид “Хуралдаан” гэх/-ыг даргалах ба хуралдааныг товлосон хугацаанд хэвийн явуулах, хуралдааныг нээх, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулах, төлөвлөсөн асуудлаа хэлэлцүүлэх, гишүүдийн саналаа илэрхийлэх, санал хураалтад оролцох боломж нөхцөлөөр хангах үүрэг хүлээх ба хуралдааны дэгийг сахиулан ажиллана.
- 3.3 Хорооны нарийн бичгийн даргыг ТМЗН-ийн ажлын албанаас томилно. Нарийн бичгийн дарга нь:
- ✓ хорооны өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах, хорооны хуралдаан болон үйл ажиллагаатай холбоотой зар хүргэх, хорооны гишүүдийг мэдээ мэдээллээр хангах;
 - ✓ бичиг хэргийг цэгцлэх, ирсэн өргөдөл гомдол болон аливаа гарсан шийдвэрээр мэдээллийн сан бүрдүүлж архивт хүлээлгэн өгөх;
 - ✓ хуралдааны тов болон хэлэлцэх асуудлыг хуралдаан эхлэхээс ажлын 2 өдрийн өмнө гишүүдэд бичгээр эсхүл цахим хэлбэрээр хүргүүлж, баримтжуулах, хуралдаан явуулах байр, танхимыг бэлтгэх, хуралдааны ирцийг бүртгэх, хуралдааны үйл ажиллагааг тэмдэглэл үйлдэж баталгаажуулах;
 - ✓ хуралдаанаас гарсан шийдвэрийн талаар холбогдох этгээдүүдэд мэдэгдэх зэрэг үүргийг хэрэгжүүлнэ.
- 3.4 ЁЗХМХ-ны гишүүдийг нээлттэй саналд үндэслэн ЁЗХМХ -ны даргын санал болгосноор Удирдах зөвлөлийн хуралдаанаар батлана.
- 3.4.1 ЁЗХМХ-нд гишүүд болон гишүүн байгууллагуудын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, түүний үндэслэлийг шалган тогтоож, дүгнэлт гаргах, тэдгээрийн үүргийн биелэлтийг хангуулахад туслалцаа үзүүлэх эрх бүхий гишүүд ажиллана.
- 3.4.2 ЁЗХМХ -ны гишүүдэд тавигдах шаардлага:
- ✓ Ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй байх;
 - ✓ Харилцааны өндөр соёлтой байх;
 - ✓ Хувийн зохион байгуулалт сайтай байх;
 - ✓ Багаар ажиллах чадвартай байх;
 - ✓ Хяналт шалгалтын чиглэлээр тодорхой мэдлэг, туршлагатай байх;
- 3.4.3 Удирдах зөвлөлийн гишүүдээс ЁЗХМ-ны үйл ажиллагаанд зөвлөх чиг үүрэгтэйгээр хорооны гишүүнээр томилогдон ажиллаж болно.
- 3.4.4 Хорооны гишүүдийн 30-аас ихгүй хувь нь эрх зүйч мэргэжилтэй гишүүн байна.
- 3.4.5 Шаардлагатай тохиолдолд гэрээт хуульч болон хөндлөнгийн шинжээчийг ажиллуулж болно.
- 3.4.6 Хорооны гишүүд нь ЁЗХМХ-ноос урьдчилан зөвшөөрөл, итгэмжлэл олгоогүй тохиолдолд хорооны болон нийгэмлэгийн нэрээр олон нийтэд хандаж хувийн байр сууриа илэрхийлсэн ярилцлага, ямар нэгэн мэдэгдэл хийхгүй байна.
- 3.4.7 Тухайн тайлант жилийн нийт хуралдааны талаас дээш хувьд оролцоогүй, нэр бүхий гишүүдийн ирцээс шалтгаалан хурал 2 удаа хойшлогдсон зэрэг тохиолдлуудад ЗҮМХ-ны дарга уг гишүүнийг эгүүлэн татах саналыг Удирдах Зөвлөлд хүргүүлж, чөлөөлүүлнэ.
- 3.5 ЁЗХМХ нь дараах эрх, үүрэгтэй ажиллана. Үүнд:

- 3.5.1 Гишүүд болон гишүүн байгууллагуудын баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, гишүүдийн үүргийн биелэлтийг хангуулах үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах;
- 3.5.2 Гомдол, мэдээлэлд холбогдох гишүүд болон гишүүн байгууллагууд, гомдол мэдээлэл гаргагчтай уулзаж, тэдний тайлбар, саналыг сонсох, холбогдох нотолгоо, материал, баримт бичгийг шаардан авах;
- 3.5.3 Гомдол, мэдээллийн нууцлалыг хадгалах, гомдол, мэдээллийг шалгасан тухай дүнг хуралдаанаар хэлэлцэж, гишүүдийн олонхийн саналд үндэслэн бусдын нөлөөнд автаагүй, нотлох баримтад үндэслэгдсэн дүгнэлт шийдвэр гаргах;
- 3.5.4 Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийгэмлэг болон нийгэмлэгийн гишүүд, гишүүн байгууллагын талаар цацагдсан мэдээллийг үндэслэлтэй үнэн, зөв эсэхийг тогтоож, дүгнэлт гаргах, ташаа мэдээлэл цацагдсан тохиолдолд залруулга хийх;
- 3.5.5 Хорооны хуралдаанд оролцож, хэлэлцэж буй асуудлаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, гаргаж буй шийдвэрийн биелэлтэд хяналт тавих;
- 3.5.6 Хорооны үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хорооны даргатай зөвшилцөж, ТМЗН-т мэдэгдсэний үндсэн дээр нийгэмлэг болон жинхэнэ гишүүн, гишүүн байгууллагаас лавлагаа, санал асуулга, судалгаа авах, дүгнэлт гаргах, нийгэмлэгийн бусад хороо, нэгж, холбогдох албан тушаалтнаас асуулт тавьж, хариулт авах, хорооны шийдвэртэй холбоотой асуудлаар үүрэг, даалгавар өгч биелэлтийг нь шаардах;
- 3.5.7 Хорооны хуралдаанаас олгосон эрхийн үндсэн дээр хорооны үйл ажиллагаа, хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэрийн талаар ТМЗН-ийн гишүүдэд болон олон нийтэд зориулан мэдээлэл хийх, ярилцлага зохион байгуулах;
- 3.5.8 Хорооны үйл ажиллагаанд идэвхтэй, бэлтгэлтэй оролцох, хорооны хуралдаан таслахгүй байж, зарласан цагт ирж байх;
- 3.5.9 Бусад гишүүдийн үзэл бодол, саналд хүндэтгэлтэй хандаж, хорооны хуралдаанаас гарсан шийдвэрийг хүндэтгэн биелүүлэх, хурлын явцад гишүүдийн болон даргалагчийн гаргасан санал, хэлсэн үгийг задруулахгүй байх;
- 3.5.10 Өөрийн ажлын байрны болон цахим (имэйл) хаяг, утасны дугаар өөрчлөгдөх бүрт хорооны нарийн бичгийн даргад мэдэгдэж байх;
- 3.6 ЁЗХМХ-ны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хорооны хуралдаан байна. Хуралдаан нь ээлжит болон ээлжит бус /цахим байж болно/ байна.
- 3.6.1 Ээлжит хуралдааныг улирал бүрийн эхний долоо хоногт хуралдуулна.
- 3.6.2 Ээлжит бус хуралдааныг шаардлагатай тохиолдолд хорооны даргын санаачлагаар зарлан хуралдуулж болно.
- 3.6.3 Хуралдааныг гишүүдийн ердийн олонхи (50+1) ирснээр хүчинтэйд тооцно.
- 3.6.4 Хуралдааны ирц нь энэ зүйлийн 3.7.3-т заасан хувьд хүрээгүй бол хуралдааныг хүчин төгөлдөр бус гэж үзэн хойшлуулж, ажлын 5 өдрийн дотор дахин хуралдуулахаар хуралдаан даргалагч товлох бөгөөд уг хуралдаан хуралдахаас ажлын 2 өдрийн өмнө хуралдаан болох өдөр, цаг, хэлбэрийг дахин мэдэгдэнэ.
- 3.6.5 Хуралдаанаар хэлэлцэх асуудал, түүний танилцуулга, гарах шийдвэрийн төслийг хуралдаан эхлэхээс ажлын 5 өдрийн өмнө гишүүдэд бичгээр эсхүл цахим хэлбэрээр хүргүүлнэ.
- 3.6.6 Гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралдаанд оролцох боломжгүй бол энэ тухайгаа албан ёсоор хорооны нарийн бичгийн даргад мэдэгдэх бөгөөд хэрвээ хуралдаанаар хэлэлцэх асуудалтай танилцаж, саналаа урьдчилан өгсөн тохиолдолд тухайн гишүүнийг хуралдаанд оролцсонд тооцно. Харин тухайн

- гишүүн нь хуралдаанаар хэлэлцэх асуудлын зарим хэсэгт нь санал өгөөгүй бол тухайн асуудлаар санал өгөөгүйд тооцно.
- 3.6.7 Хэлэлцэж буй асуудлыг нууц санал хураалтаар шийдвэрлэхээр хорооны гишүүдийн 30-аас дээш хувь нь санал гаргасан бол тухайн асуудлыг нууц санал хураалтаар шийдвэрлэнэ.
- 3.6.8 Хуралдааныг хэзээ, хаана хийсэн, хуралдаан эхэлсэн, дууссан цаг, хуралдаанд оролцсон гишүүд болон бусад хүмүүсийн нэр, гишүүдийн ирцийн хувь хэмжээ, хуралдаанаар хэлэлцсэн асуудлын дараалал, хэлэлцсэн асуудал бүрээр гишүүдийн өгсөн санал, дүгнэлт, асуулт хариулт, саналын хуудас хэрэглэсэн бол түүний загвар, гаргасан шийдвэрийн бүрэн томъёолол зэрэг мэдээллийг хуралдааны тэмдэглэлд үлдээнэ. Хуралдааны тэмдэглэлийг бүрэн гүйцэд тэмдэглэх зорилгоор дуу бичлэгийн техник, хэрэгсэл ашиглаж болно.
- 3.6.9 Хуралдааны тэмдэглэлийг хурал дууссан өдрөөс хойш 5 өдрийн дотор бэлэн болгож, хуралдаан даргалагч, хуралдааны нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурсан байна
- 3.7 ЁЗХМХ -ны хуралдаанд дараах дэгийг баримтлана. Үүнд:
- ✓ Хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоож, хэлэлцэж буй асуудалтай холбогдолтой танилцуулга, тайлбарыг хурал даргалагч болон асуудал оруулж байгаа гишүүн хийнэ.
 - ✓ Хуралдаанд оролцогчид асуулт асуух, санал дүгнэлт гаргахдаа даргалагчаас тогтоосон дарааллыг баримтлана.
 - ✓ Гишүүн ашиг сонирхлын зөрчлийн улмаас тухайн хэлэлцэж буй асуудлаар санал хураалтад оролцохгүй байж болно.
 - ✓ Хороо нь шийдвэрээ ил санал хураалтын үндсэн дээр хуралдаанд оролцогчдын ердийн олонхийн саналаар гаргана. Гишүүн хэлэлцэж буй асуудлаар нэг саналын эрх эдэлнэ. Санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

Дөрөв. ЁЗХМХ-ны үйл ажиллагаа, үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл

- 4.1 ЁЗХМХ нь үйл ажиллагаагаа:
- 4.1.1 Хяналт шалгалтын үйл ажиллагаа;
- 4.1.2 Дүгнэлт гаргах, шийдвэрлэх үйл ажиллагаа;
Энэ зүйлийн 4.1.1-4.1.2-т заасан үйл ажиллагаанд “ТМЗН-ийн гишүүд, гишүүн байгууллагуудын ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ыг баримтлана. /ТМЗН-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 4-р сарын 06-ны өдрийн 009 тогтоолын 2-р хавсралт/
- 4.1.3 Гишүүд болон гишүүн байгууллагуудын үүргийн биелэлтийг хангуулах; ТМЗН-ийн дүрэмд заасны дагуу гишүүдийн үүргийн биелэлтийг хангуулан ажиллана. /ТМЗН-ийн 2017 оны 5-р сарын 12-ны өдрийн бүх гишүүдийн хурлаар батласан/
- 4.1.4 Бусад үйл ажиллагаа; ТМЗН-ийн зүгээс зохион байгуулагдах аливаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно.
- 4.2 ЁЗХМХ нь жил бүрийн 12 дугаар сарын 15-наас өмнө ирэх жилийн ажлын төлөвлөгөөгөө хорооны хуралдаанаар хэлэлцэн батална.
- 4.3 Хорооны дарга нь энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан төлөвлөгөөг ТМЗН-ийн Ерөнхийлөгчөөр батлуулснаар үйл ажиллагааны төлөвлөгөө нь албан ёсоор хүчин

- төгөлдөр болох бөгөөд ТМЗН-ийн хөдөлмөрийн дотоод журмын 3-р зүйлийн 3.1.5-д заасны дагуу ТМЗН-ийн гүйцэтгэх удирдлагад хүргүүлнэ.
- 4.4 Хорооны ажлын төлөвлөгөө нь ТМЗН-ийн тухайн үеийн стратегийн зорилго, зорилгод нийцсэн буюу түүнд үндэслэгдсэн байна. Шаардлагатай тохиолдолд хороо нь цаг үеийн нөхцөл байдлаар төлөвлөгөөт бус ажлууд зохион байгуулж, гүйцэтгэж болно. Энэ тохиолдолд ТМЗН-ийн Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захиралтай зөвшилцсөн байна.
- 4.5 Хорооны дарга нь төлөвлөгөөний хэрэгжилт, хүрсэн үр дүнгээ жилийн эцэст Удирдах зөвлөлөөр дүгнүүлж нийт гишүүдэд гишүүний програмаар нээлттэй тайлагнах зарчмыг баримтална.

Тав. ЁЗХМХ-ны үйл ажиллагааны санхүүжилт, төсөв

- 5.1 ЁЗХМХ нь чиг үүрэг, зорилгоо хангахад шаардлагатай санхүүгийн эх үүсвэртэй байна.
- 5.2 ЁЗХМХ-ны үйл ажиллагааг санхүүгийн дараах эх үүсвэрээр санхүүжүүлнэ. Үүнд:
- 5.1.1 ТМЗН-ийн хөдөлмөрийн дотоод журмын 5-р зүйлийн 5.5.9-д заасны дагуу үйл ажиллагааны санхүүжилтийг улирал бүр авах;
 - 5.1.2 Олон улсын болон гадаад, дотоодын байгууллагын төслийн санхүүжилт;
 - 5.1.3 ТМЗН-ийн дүрэмд харшлаагүй бусад эх үүсвэр;
- 5.3 Томилолтын зардлын хэмжээг ТМЗН-ийн хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу олгоно.
- 5.4 Хорооны дарга тухайн жилийн санхүүжилт болон үйл ажиллагааны зардлын тайланг гаргаж УЗ-д тайлагнана.

Зургаа. Бусад асуудал

- 6.1 Монгол Улсын хууль тогтоомж болон байгууллагын нууцлалын журмын дагуу хорооны дарга, гишүүд нь ТМЗН-тэй нууцлалын гэрээ байгуулж ажиллана.
- 6.2 Энэ журмыг 2018 оны 4-р сарын 06-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
- 6.3 ТМЗ, ТМЗҮ эрхэлж буй хуулийн этгээд нь сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдлоо гаргаж болно.

*Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 4-р сарын 30-ны
өдрийн 010 тогтоолын 2-р хавсралт*

**ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН НИЙГЭМЛЭГИЙН ГИШҮҮД,
ТМЗҮ ЭРХЭЛЖ БҮЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЁС ЗҮЙТЭЙ ХОЛБООТОЙ
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ**

Нэг: Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмаар Татварын мэргэшсэн зөвлөх /цаашид гишүүн гэх/ болон Татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээ эрхэлж буй хуулийн этгээд /цаашид гишүүн байгууллага гэх/-тэй холбоотой гомдол, мэдээлэл хүлээн авах, түүнийг шийдвэрлэх үйл ажиллагааг зохицуулна.
- 1.2 Ёс зүй хяналтын менежментийн хороо /цаашид Хороо гэх/ нь Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг /цаашид ТМЗН/-ийн гишүүд болон гишүүн байгууллагын ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийн талаархи нууцыг чандлан хадгална.
- 1.3 Өргөдөл, гомдол гаргагч нь өргөдөл гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэхдээ Үндсэн хууль, бусад хуулийг зөрчих, бусдын эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хохироох, ялгаварлан гадуурхахгүй байна.

Хоёр. Нэр томъёоны тайлбар

- 2.1 Энэ журамд заасан дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 2.1.1 "Санал" ТМЗН-ийн гишүүд болон гишүүн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан хүсэлтийг;
 - 2.1.2 "Мэдээлэл" гэж иргэдээс ирүүлсэн мэдэгдлийг;
 - 2.1.3 "Өргөдөл, гомдол" гэж ТМЗН болон ТМЗН-ийн гишүүн, гишүүн байгууллагын шийдвэр, үйл ажиллагаагаар гомдол гаргагчийн эрх нь зөрчигдсөн гэж үзэж гаргасан хүсэлтийг;
 - 2.1.4 "Өргөдөл, гомдол, мэдээллийг шийдвэрлэх" гэж гомдол, мэдээлэлд дурдсан асуудлыг бүх талаас нь судлан үзэж, түүний дагуу хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох арга хэмжээ авсныг мэдэгдэж, энэ журамд заасан хугацаанд багтаан хариу өгөхийг;

Гурав. Өргөдөл, гомдол хүлээн авах

- 3.1 ТМЗН-ийн гишүүд болон гишүүн байгууллагын ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг зөвхөн бичгээр хүлээн авна. Өргөдөл, гомдол гаргагч нь өөрийн овог, нэр, оршин суугаа газрын болон өөрийн цахим хаяг /байгууллагын нэр, хаяг/, холбоо барих утасны дугаарыг бичиж, гарын үсгээ зурсан байна.
- 3.2 ТМЗН-ийн гишүүд болон гишүүн байгууллагын ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол гаргагч нь нийгэмлэгийн бичиг хэрэгт өргөдөл, гомдлоо албан ёсоор хүлээлгэн өгнө.
- 3.3 Өргөдөл, гомдол гаргагч нь мэдээллийн үнэн бодит байдлыг бүрэн хариуцах бөгөөд холбогдох нотлох баримтыг бүрдүүлж өгвөл зохино.
- 3.4 ЁЗХМХ-ны менежер нь ирсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, энэ журмын 3.1-д заасан шаардлагыг хангасан гэж үзвэл бүртгэлд бүртгэж, шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтанд өдөрт нь хүлээлгэн өгнө. Шаардлага хангагдаагүй өргөдөл гомдлыг буцаана.
- 3.5 ЁЗХМХ-ны менежер нь ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол болон эцсийн шийдвэрийн хүрээнд мэдээллийн сан бүрдүүлж ажиллах бөгөөд нэг хувийг ТМЗН-ийн архивт хүлээлгэн өгнө.

Дөрөв. Өргөдөл, гомдол, мэдээллийг шалгах үйл ажиллагаа

- 4.1 ЁЗХМХ-ны дарга нь гишүүд болон гишүүн байгууллагын ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авч танилцаад ажлын 5 хоногийн дотор “Хянан шалгагч”-ийг, шаардлагатай гэж үзвэл “Хяналт шалгалтын баг”-ийг томилж ажиллуулна.
- 4.2 Хяналт шалгалтын баг нь 3-аас доошгүй гишүүнтэй байна.
- 4.3 Хяналт шалгалтын баг нь гомдол, мэдээллийн дагуу шалгахдаа анхан шатны баримт, гэрчүүдийн мэдүүлэг, бусад шаардлагатай нотлох баримт материалууд дээр үндэслэх бөгөөд асуудалд шударга ёсыг баримтлан бодитой хандана.
- 4.4 Хяналт шалгалтын баг нь гишүүд болон гишүүний байгууллагын ёс зүйн шаардлага биелүүлээгүй шалтгаан болон үндэслэл бүхий тайлбарыг бичгээр гаргуулан авсан байна.
- 4.5 Хяналт шалгалтын баг нь шаардлагатай гэж үзвэл гомдол, мэдээлэлд холбогдох гишүүн эсвэл гишүүн байгууллагын эрх бүхий албан тушаалтан болон гомдол, мэдээлэл гаргагчтай уулзаж, тэдний тайлбар, саналыг сонсох, холбогдох нотолгоо, материал, баримт бичгийг шаардах эрхтэй.
- 4.6 Хяналт шалгалтын баг нь шалгах ажлыг хүлээн авснаас хойш ажлын 20 хүртэл хоногийн хугацаанд дүгнэлт гаргах бөгөөд ёс зүйн зөрчилд холбогдсон гишүүнд дүгнэлтийг дүгнэлт гарахаас өмнө танилцуулсан байна.
- 4.7 Хяналт шалгалтын ажлын цар хүрээнээс хамааран өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хугацааг ЁЗХМХ-ны дарга нэг удаа ажлын 20 хоногоор сунгаж болно.

Тав. Ёс зүйн хяналт шалгалтын багийн дүгнэлтийг хэлэлцэх, шийдвэрлэх

- 5.1 Хяналт шалгалтын дүгнэлт гарснаас хойш ажлын 5 хоногийн дотор дүгнэлтийг ЁЗХМХ-ны хуралдаанаар хэлэлцэнэ.
- 5.2 Хянан шалгагч эсвэл багийн дүгнэлтийг хэлэлцэх Хорооны хуралдаанд ёс зүйн зөрчилд холбогдсон этгээдийг оролцуулж болно.
- 5.3 ЁЗХМХ-ны дүгнэлтэд хорооны дарга, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.
- 5.4 ЁЗХМХ нь тухайн ёс зүйн зөрчилд холбогдсон гишүүнд сахилгын шийтгэл ногдуулах нь зүйтэй гэж үзсэн бол хурлаас гарсан дүгнэлтийг ажлын 5 хоногийн дотор ТМЗН-ийн Удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагад уламжилна.
- 5.5 ТМЗН-ийн Удирдах зөвлөлөөр хянагдсан албан ёсны шийдвэрийг шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор холбогдох этгээдэд хүргүүлсэн байна.

Зургаа. Ёс зүйн зөрчлийг шийдвэрлэх

- 5.6 ТМЗН-ийн Удирдах зөвлөл нь ТМЗ-ийн ёс зүйн дүрмийн 11.5 заалтыг үндэслэн ЁЗХМХ-ноос ирүүлсэн дүгнэлтийг хэлэлцэж, шийдвэрлэнэ.
- 5.7 ТМЗН-ийн Удирдах зөвлөл нь ЁЗХМХ-ноос гаргасан дүгнэлтийг хянаж үзээд, дараахь үндэслэлээр дахин шалгуулахаар ЁЗХМХ-нд буцаах шийдвэр гаргаж болно. Үүнд:
 - ✓ Ёс зүйн зөрчил гаргасан нотолгоо, баримт бичгийн бүрдэл гүйцэд хангагдаагүй;
 - ✓ Холбогдох баримт, бичиг, материалыг гүйцэд шалгаагүй;
- 5.8 Гомдол, мэдээллийг үндэслэлгүй болохыг тогтоосон дүгнэлтийг хорооны хуралдаанаар хэлэлцээд зүйтэй гэж үзсэн тохиолдолд шийдвэрийг холбогдох талуудад албан ёсоор бичгээр мэдэгдэнэ.
- 5.9 ТМЗН-ийн Удирдах зөвлөл нь Гишүүний гаргасан ёс зүйн зөрчлийн шинж байдлыг харгалзан үзэж, сахилгын шийтгэл ногдуулах эсэх талаар шийдвэр гаргах бөгөөд сахилгын шийтгэл ногдуулах нь зүйтэй гэж үзсэн бол ТМЗ-ийн Ёс зүйн дүрмийн 11.6-д заасны дагуу дараах сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна. Үүнд:
 - 5.9.1 **Сануулах:** Дараах тохиолдолд “Сануулах” сахилгын шийтгэл ногдуулна.
 - ✓ Хүчин төгөлдөр бус, хуурамч баримтаар гүйлгээ хийсэн;

- ✓ Өөрийн ажил үүргийн дагуу шууд хяналт тавих албан тушаалыг хавсран гүйцэтгэсэн;
 - ✓ Хэт нэг талыг баримталсан дүгнэлт гаргасан, дүгнэлтийн үндэслэлийг тайлбарлахаас зайлсхийсэн;
 - ✓ ТМЗ үйлчилгээний тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжуудыг зөрчсөн нь тогтоогдсон;
 - ✓ Ёс зүйн дүрэмд заасан бусад үндэслэл;
- 5.9.2 **ТМЗУ эрхлэх хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх;** Саналыг Сангийн яаманд хүргүүлнэ. Үүнд:
- ✓ ТМЗҮТХ-ийн 13.1 зүйл;
- 5.9.3 **ТМЗУ эрхлэх хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох;** Саналыг сангийн яаманд хүргүүлнэ. Үүнд:
- ✓ ТМЗҮТХ-ийн 13.2 зүйл;
- 6.2.3 **ТМЗ эрхийг хүчингүй болгох.** Саналыг Сангийн яаманд хүргүүлнэ. Үүнд:
- ✓ ТМЗҮТХ-ийн 20.1, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 20 дугаар зүйл болон бусад холбогдох хууль, тогтоомжуудыг удаа дараа зөрчсөн нь тогтоогдсон;
 - ✓ Мэргэжлийн нэр хүнд унагасан үйлдэл гаргасан нь шүүхээр тогтоогдсон;
 - ✓ Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 1 жил ба түүнээс дээш хугацаагаар гишүүний эрхээ сунгуулаагүй;
 - ✓ 3 жил ба түүнээс дээш хугацаагаар гишүүний үүргийн биелэлтийг хангаж ажиллаагүй;
 - ✓ Тусгай зөвшөөрөл авахдаа болон ТМЗ-ийн шалгалтад орохдоо хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;
 - ✓ Ёс зүйн дүрэмд заасан бусад үндэслэл.
- 6.3 “Сануулах” сахилгын шийтгэл нь оногдуулсан өдрөөс хойш нэг жилийн дотор дахин сахилгын шийтгэл ногдуулаагүй бол сахилгын шийтгэлгүйд тооцно.
- 6.4 “Сануулах” сахилгын шийтгэл 2 удаа авсан гишүүн дахин ёс зүйн зөрчил гаргавал дараагийн шатны сахилгын шийтгэл ногдуулна.
- 6.5 Нэг төрлийн зөрчилд сахилгын шийтгэлийг давхардуулан ногдуулж болохгүй.
- 6.6 Хороо нь сахилгын шийтгэл ногдуулсан тухай ТМЗН-ийн вэб хуудас болон “Шинэ хишигтэн” сониноор дамжуулан нийтэд мэдээлэх үүрэгтэй.
- 6.7 Ёс зүйн зөрчил нь гэмт хэргийн болон авлигын шинжтэй бол холбогдох байгууллагад шилжүүлэх үүргийг Удирдах зөвлөлөөс хороонд даалгаж болно.
- 6.8 ТМЗ-ийн эрх нь хасагдсан гишүүн нь ТМЗҮТХ-ийн 17-р зүйлийн 17.2-т заасны дагуу шинээр эрх авах тухай хүсэлт гаргаж болно.
- 6.9 ТМЗН-ийн Удирдах зөвлөлийн шийдвэр нь гишүүдийн ТМЗ-ийн эрхийг хүчингүй болгох, ТМЗУ эрхэлж буй хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх эсвэл хүчингүй болгосон бол тухайн шийдвэрийг Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.

Долоо. Бусад

- 7.1 Монгол Улсын хууль тогтоомж болон байгууллагын нууцлалын журмын дагуу ЗҮМХ-ны дарга, гишүүд нь ТМЗН-тэй нууцлалын гэрээ байгуулж ажиллана.
- 7.2 Энэ журмыг 2018 оны 4 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

7. ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАНГИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэх СЯ-1605 тоот гэрээний хэрэгжилтийн тайлан нийт 119 хуудас болно.

Захиалагчийг төлөөлж:

САНГИЙН САЙД:
Ч.ХҮРЭЛБААТАР

САНГИЙН ЯАМНЫ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА:
Ч.ЧИМИДСҮРЭН

САНГИЙН ЯАМНЫ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН:
Б.БОЛОРМАА

Гүйцэтгэгчийг төлөөлж:

ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН НИЙГЭМЛЭГИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:
Ц.БОЛОРМАА

ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН НИЙГЭМЛЭГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮН:
Л.НЯМСҮРЭН

ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН НИЙГЭМЛЭГИЙН ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ:
Г. ХИШИГЗУЛ
